

НИЙГМИЙН ТУХАЙ МЭДЛЭГ

2011

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

- Нийгмийн үйл хэрэгт идэвхитэй, ухамсартай оролцож, нийгмийн хэм хэмжээг даган баримталдаг хүнийг философид юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
 А. Хүн В. Бие хүн С. Бодгаль хүн
 D. Энэ гурваас өөр хүн E. Гэгээрсэн хүн
- Нийгмийн давхраажилтын хэмжигдэхүүнд үл хамаарах зүйл дурдсан бол аль нь вэ? (1 оноо)
 А. Эд баялаг В. Эрх мэдэл С. Нэр хүнд
 D. Боловсрол E. Гэрлэлт
- Аль нь төрөлх статус вэ? (1 оноо)
 А. Миний ээж буриад ястан В. Ах маань оюутан болсон
 С. Дорж хуульч хийж байгаа D. Миний дүү 6 нас хүрч сургуульд оров
 E. Боксчин Бадар-Ууган хөдөлмөрийн баатар боллоо.
- Холбогдох хуулийн үүднээс өндөр насны тэтгэврийн даатгал нь аль хэлбэрт хамаарах вэ? (1 оноо)
 А. Заавал даатгуулах В. Сайн дурын даатгал
 С. Аль нь ч байж болдог D. Хуулинд энэ тухай заалт байхгүй
 E. Индексжүүлсэн даатгал
- Иргэдийнхээ тэр дундаа эмзэг бүлгийнхний нийгмийн нөхцөл байдлыг сайжруулах, эрсдэлд өртүүлэхгүйн тулд төрөөс цогц арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Энэ ямар арга хэмжээ вэ? (1 оноо)
 А. Нийгмийн хамгаалал В. Нийгмийн даатгал
 С. Нийгмийн халамж D. Хадгаламжийн тэтгэмж
 E. Эмзэг бүлгийнхэнд зориулсан тэтгэмж
-бол нийгмийн зохион байгуулалттай тодорхой хүчнээс хүн амын янз бүрийн бүлгийн харилцаа ба үйл ажиллагаагаар өөртөө учруулах бэрхшээл эсэргүүцлийг даван туулж өөрийн зориг хүслийг эрхзүй, ёс суртахууны зэрэг нийтлэг хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрүүлэх чадвар юм. (1 оноо)
 А. Төрийн засаглал В. Хүч чадал
 С. Улс төрийн ёс суртахуун D. Улс төрийн хүсэл зориг
 E. Улс төрийн засаглал
- Улс төрийн амьдрал нэг талаасаа зөрчилт чиглэлийг агуулж байдаг. Тиймээс энэ утгаараа улс төр гэдэг нь “хэн, юуг, хэзээ, хэрхэн олж авах” тухай асуудал юм гэж хэн тодорхойлсон бэ? (1 оноо)
 А. К. Маркс В. Р. Даль С. Х. Лассуэл
 D. Аристотель E. Б. Рассель
- Эрх мэдлийг ангилах шалгуур үзүүлэлт маш олон төрөл байдаг хэдий ч бид эрх мэдлийг ангилах дараах үзүүлэлтүүдийг авч үзсэн болно. Тэгвэл дараах ангиллын зөв харгалзааг тогтооно уу? (3 оноо)
 1. Эрх мэдлийг субъектээр нь а. Ардчилсан, ардчилсан бус
 2. Хэрэгжүүлж буй аргаар нь б. Гэр бүлийн, цэргийн, намын
 3. Тулгуурлаж буй эх сурвалжаар нь в. Эдийн засгийн, мэдээллийн, албадлагын
 4. Багтаамжаар нь г. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх
 5. Гүйцэтгэж буй үүргээр нь д. Бага, дунд, өргөн
 А. 1б2а3в4д5г В. 1в2а3б4д5г С. 1а2б3в4г5д
 D. 1г2а3в4д5б E. 1д2а3в4г5б
- 1930-аад оны үеийн дэлхийн эдийн засгийн хямралын шалтгааныг тодорхойлж зах зээлд төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатайг онцолсон эдийн засагч хэн бэ? (1 оноо)
 А. А. Смит В. М. Кейнс С. А. Маршал
 D. К. Маркс E. Ф. Энгельс
- Мөнгөний бодлого гэж юу вэ? (1 оноо)
 А. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд оруулах
 В. Банк хоорондын төлбөр тооцоог зохицуулах
 С. Арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих
 D. Эдийн засаг дахь мөнгөний нийт тоонд болон тэдгээрийг тавьж олгох өртөгт нөлөөлөх
 E. Гадаад валютын улсын нөөцийг зохицуулах
- 1991 оноос Монголд бага хувьчлалын үе эхэлсэн бөгөөд Монголын засгийн газраас ард түмэндээ олгосон анхны хувийн өмчийн хэлбэр юу вэ? (1 оноо)
 А. Мал В. Орон сууц С. Улсын үйлдвэр
 D. Хувьцаа E. Газар

12. Бөөний үнэ дээр борлуулалтын зардал болон ашгийг нэмсэн нь ямар үнэ вэ? (1 оноо)
 А. Үйлдвэрлэлийн үнэ В. Жижиглэнгийн үнэ С. Үнэмлэхүй үнэ
 D. Эдгээрээс өөр E. Бүх хариулт буруу
13. Цэгийн оронд тохирохыг сонго. Соёлуудын харилцан тархалт, дэлгэрэлтийг соёлын үзээгдэл гэнэ. (1 оноо)
 А. Холбох В. Нэвчих С. А ба В хариулт зөв
 D. Холилдох E. Аль нь ч биш
14. Мэндчилгээ, зочлох ёс, харилцааны хэв маяг, орон байр, хоол бэлтгэх, ажилдаа хандах хандлага зэрэг нь..... (1 оноо)
 А. Соёлын түгээмэл шинжийг илэрхийлнэ В. Соёлын олон талт байдлыг илэрхийлнэ.
 C. Соёлын түгээмэл биш шинжийг илэрхийлнэ. D. Соёлын онцгой шинжийг илэрхийлнэ.
 E. Аль нь ч биш
15. Олон улсын харилцааны гол субъектүүдийг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? (1 оноо)
 А. Төр В. Ард түмэн
 C. Олон улсын байгууллага D. Үндэстэн дамнасан корпораци
 E. Гадаадын хөрөнгө оруулалттай ХХК
16. Дэлхийн талыг байлдан дагуулж байсан Эзэнт гүрний үед ч хөрш орнуудтай элч илгээх, бичиг захидал солилцох, худалдаа наймаа хийх, худ ураг бололцох, найрамдах, дайтах зэргээр харилцаж ирсэн. Чухам энэ үеэс эхлэн Монгол улсын гадаад харилцаанб үндсэн чиглэл хөгжсөн гэж үздэг. Дээрх нь ямар бодлого вэ? (2 оноо)
 А. Хэн хүчтэй бол түүний зөв гэсэн дайнч бодлого
 B. Бусад үндэстэнг эрхшээлдээ оруулах дайнч бодлого
 C. Энхийг эрхэмлэсэн шинжтэй бодлого
 D. Бусдын хамгаалал нөлөөнд орж хараат байх бодлого
 E. Бусдыг аялдан дагах бодлого
17. Урьдчилан бэлтгэсэн асуулт, хариулт бүхий хуудсаар мэдээлэл цуглуулах аргыг юу гэдэг вэ? (1 оноо)
 А. Ярилцлага В. Анкет буюу асуулга С. Ажиглалт
 D. Туршилтын арга E. Эдгээрээс өөр
18. Ажиглалтын аргыг аль нь тодорхойлж байна вэ? (1 оноо)
 А. Үзэгдлийг мэдрэхүйгээрээ танин мэдэхүй
 B. Үзэгдлийг тодорхой зорилготойгоор мэдрэхүйгээр дамжуулан сэтгэхүйн түвшинд танин мэдэхүй
 C. Тухайн үзэгдлийн байдлыг тандан харзгахуй
 D. Үзэгдлийг тодорхой бус зорилготойгоор дамжуулах
 E. Аль нь ч биш
19. МУ-ын төрийн далбааны аль хэсэгт нь алтан соёмбыг байрлуулдаг вэ? (1 оноо)
 А. Далбааны гол хэсэгт
 B. Далбааны шар дэвсгэрийн голд
 C. Далбааны улаан дэвсгэрийн голд
 D. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн голд
 E. МУ-ын төрийн далбаан дээр соёмбо байдаггүй
20. Эдийн засгийн сэтгэлгээний түүхэн дэх баялгийн тухай ойлголтыг зөв харгалзуул. (4 оноо)
 1. Меркантилизм а. Гүйлгээний хүрэн дэх мөнгө бол үндэсний баялаг
 2. Физиократууд б. Ашиг хонжоо хайсан үйл ажиллагаа нь эцсийн дүнд баялгийг бүтээдэг
 3. Сонгодог онол в. ХАА, газар тариалангийн бүтээгдэхүүн жинхэнэ баялаг
 4. Шинэ сонгодог г. Ажилчны бүтээсэн хөлсний хөдөлмөрийг капиталист мөлжих замаар ашгийг бүтээдэг
 А. 1а 2б 3в 4г В. 1а 2в 3б 4г С. 1г 2б 3в 4а
 D. 1в 2б 3а 4г E. 1г 2а 3в 4б
21. Зах зээлийн харилцаа эдийн засгийн үндсэн үйл явцуудын алин дээр нь илэрдэг вэ? (1 оноо)
 А. Үйлдвэрлэлт В. Хувиарлалт С. Арилжаа
 D. Хэрэглээ E. Түгээлт
22. Эдийн засгийн институтын чиг үүргийг тодорхойлно уу. (2 оноо)
 А. Хууль дүрэм ба хэм хэмжээнүүдийг дэмжих хэрэгцээг хангах
 B. Хоол хүнс, хувцас, орон байр олох хэрэгцээг хангах
 C. Хүмүүсийг нийгэмшүүлэх, соёлжуулах хэрэгцээг хангах
 D. Үр хүүхдээ өсгөх, халамжлах хэрэгцээг хангах
 E. Иргэдийн шүтэх бишрэх хэрэгцээг хангах

23. Цэгийн оронд тохирох үгийг ол. Хүний хангагдаагүй хүслийг.....гэнэ. (1 оноо)
 А. Нөөц В. Эрэлт С. Өртөг D. Хэрэгцээ E. Хүсэл
24. Аль нотолгоо нь үнэн бэ? (3 оноо)
 А. Арилжааны банк хүүгийн бодлого авч явуулдаг
 В. Төв банк мөнгөн хадгаламж хүлээж авдаг
 С. Арилжааны банк, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулдаг
 D. Төв банк гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж зохицуулах үүрэг хүлээж байдаг
 E. Эдгээр ойлголт бүгд буруу
25. Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг зөв харгалзуул. (4 оноо)


1.	Европын холбоо	a.	Ази, Европын орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх байгууллага
2.	Зүүн өмнөд азийн орнуудын холбоо /АСЕАН/	b.	Европ тивийн улс түмний нягт холбоог бий болгох, эдийн засгийн тэнцэлтэй байнгын дэвшилд дөхөм үзүүлэх, гадаад болон аюулгүй байдалд нийцсэн бодлого явуулж олон улсын харилцаанд Европын нэгдмэл шинж чанарыг бататгах, нийтлэг өв уламжлалыг хадгалан бэхжүүлэх зорилго бүхий байгууллага
3.	Ази, Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга /АПЕК/	c.	Зүүн өмнөд Азийн эдийн засаг, нийгэм, соёлын салбарт хамтын ажиллагааг зохион байгуулах, энх тайван тогтвортой байдлыг буй болгоход дөхөм үзүүлэх зорилготой байгууллага
4.	Ази- Европын уулзалт /АСЕМ/	d.	Ази, Номхон далайн бүсэд олон талын чөлөөт худалдааны хөрөнгө оруулалтын нээлттэй зах зээл бий болгоход дөхөм үзүүлэх зорилготой байгууллага

- А. 1b 2c 3d 4a В. 1b 2a 3d 4c С. 1c 2d 3a 4b
 D. 1d 2a 3b 4c E. 1c 2d 3b 4a
26. Эдийн засгийн тогтолцооны төрлүүдийг түүхэн үетэй нь зөв харгалзуулна уу? (4 оноо)
 1. Уламжлалт эдийн засгийн тогтолцоо а. Богд хаант Монгол улс
 2. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо б. Монгол улс
 3. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоо в. БНМАУ
 А. 1a 2б 3в В. 1a 2в 3б С. 1б 2a 3в
 D. 1в 2б 3a E. 1б 2в 3a
27. Гэр бүлийн засаглалын тогтолцоонд эх юмуу эхнэр голлох ёсыг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
 А. Полигени В. Матриархаль С. Матрилокаль
 D. Эндогами E. Патрилокаль
28. Тусгай юмс үзэгдлүүд, баримтуудаас ерөнхий үндэслэл, дүгнэлт гаргах нь ... юм. /Нөхнө үү/ (1 оноо)
 А. Анкетын арга В. Анализ С. Синтез
 D. Индукцийн арга E. Дедукцийн арга
29. Нийгмийн жижиг бүлгийн үндсэн шинжийг тодорхойлно уу. (1 оноо)
 А. Гишүүд нь орон зайн хувьд ойр байдаг В. Гишүүдийн зан байдлыг албан бусаар хянадаг
 С. Бүлэгт сайн дурын үндсэн дээр элсдэг D. А, С хариулт зөв
 E. Дээрх бүгд
30. Улс төрийн намыг баримталж буй үзэл суртлын агуулгаар нь хэрхэн ангилдаг вэ? (2 оноо)
 А. Боловсон хүчний, олон түмний В. Эрх баригч, сөрөг
 С. Зүүний, барууны, төвийг сахисан D. Коммунист, консерватив, либерал
 E. Хувьсгалт, уламжлалт
31. Улс төрөөс бусдыг зөвшөөрнө гэсэн уриаг аль дэглэмийн үед баримталдаг вэ? (2 оноо)
 А. Улс төрийн ардчилсан тогтолцооны үед В. Тоталитар дэглэмийн үед
 С. Авторитар дэглэмийн үед D. Охлократ дэглэмийн үед
 E. Аль нь ч биш
32. Аль нь төрийн тухай илүү зөв тодорхойлолт вэ? (2 оноо)
 А. Төр бол дарлагч ангийн ноёрхлын зэвсэг мөн
 В. Төр бол тодорхой газар нутаг дээр засаглалын дээд эрх мэдлийг эдэлдэг улс төрийн байгууллага мөн
 С. Төр бол нийтийн сайн сайхны төлөө байгууллага мөн
 D. Төр бол нийгмийн тодорхой бүлгийн эрх ашгийг хамгаалах байгууллага мөн
 E. Төр бол нийгмийн дэг журмыг хангагч байгууллага мөн

33. Аль нь макро эдийн засгийн судалгаа вэ? (1 оноо)
 А. Монголын ДНБ-ий өсөлт
 В. Японы зах зээлийн судалгаа
 С. Солонгосын автомашины үнэ
 Д. Америкийн жижиг үйлдвэрлэлийн судалгаа
 Е. Дээрх бүгд

34. Үнэ буурвал эрэлтийн тоо хэмжээ нэмэгдэж, үнэ өсөхөд эрэлтийн тоо хэмжээ буурах барааг ямар бараа гэх вэ? (1 оноо)
 А. Хэвийн бараа
 В. Онцгой бараа
 С. Өргөн хэрэглээний бараа
 Д. Энгийн бараа
 Е. Дорд бараа

35. Бүтээгдэхүүний үнэ өсөхөд эрэлтийн тоо хэмжээ буурах, бүтээгдэхүүний үнэ буурахад эрэлтийн тоо хэмжээ өсөх зүй тогтлыг эрэлтийн хууль гэх бөгөөд үүнийг эрэлтийн муруйгаар илэрхийлнэ үү? (2 оноо)



36. Зах зээлд оролцогч үндсэн субъектүүдийг дурьдахад илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
 А. Хэрэглэгч
 В. Борлуулагч
 С. Компани
 Д. Бэлэн мөнгө
 Е. Үйлчлүүлэгч

37. ҮНБ-ийг зарцуулалтаар тооцохдоо ямар үзүүлэлтийг харгалзахгүй вэ? (2 оноо)
 А. Түрээс
 В. Хэрэглээ
 С. Хөрөнгө оруулалт
 Д. Улсын зарцуулалт
 Е. Цэвэр экспорт

38. Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ урьдын адил байхад нэмж ажилчин авч ажиллуулснаар хугацаа хэмнэсэн бол ... /Нөхнө үү/ (1 оноо)
 А. Хөдөлмөрийн бүтээмж өснө
 В. Хөдөлмөрийн бүтээмж буурна
 С. Материалын бүтээмж өснө
 Д. Материалын бүтээмж буурна
 Е. Ашиг нэмэгдэнэ

39. Орлого Татвар
 100.000 төгрөг 5000 төгрөг
 200.000 төгрөг 20.000 төгрөг
 Дээрхи татварыг.....гэнэ. (2 оноо)
 А. Өсгөн нэмэгдүүлэх татвар
 В. Өсгөн бууруулах татвар
 С. Хувь тэнцүүлсэн татвар
 Д. Нэмүү өртгийн татвар
 Е. Онцгой албан татвар

40. Хүмүүс өөрсдийнхөө янз бүрийн үйл ажиллагааг ивээн тэтгэж байдаг янз бүрийн бурхад оршдог хэмээн сэтгэж олон бурхны тухай хийсвэрлэл гаргаж ирсэн. Энэ нь шүтлэгийн аль хэлбэр вэ? (1 оноо)
 А. Монотеизм
 В. Политеизм
 С. Анимизм
 Д. Тотемизм
 Е. Фетишизм

41. Улс төрийн соёл нь улс төрийн системтэй хэрхэн холбогддог вэ? (2 оноо)
 А. Улс төрийн систем нь улс төрийн соёлынхоо дэд систем нь болдог
 В. Улс төрийн систем нь улс төрийн системийнхээ дэд систем нь болдог
 С. Эдгээр 2 ойлголт нь өөр хоорондоо ямар ч харилцан хамааралгүй ойлголтууд юм
 Д. Дээрх хоёр ойлголтыг гуравдагч ойлголтын тусламжтайгаар тодорхойлж болох юм
 Е. Дээрх ойлголтууд нь агуулгын хувьд харилцан тэнцвэртэй ойлголтууд

42. Улс төрийн соёл нь улс төрийн ухамсраас юугаараа ялгаатай вэ? (2 оноо)
 А. Улс төрийн соёл бол улс төрийн системтэй холбоотой ойлголт учраас улс төрийн ухамсраас ялгаатай
 В. Улс төрийн соёл нь зөвхөн билэг тэмдгийн тогтолцоогоор илэрхийлэгддэгээрээ ялгаатай юм
 С. Улс төрийн соёл нь улс төрийн үзэгдэл үйл явцын талаар хүмүүсийн ухамсарт гүн гүнзгий шингэж үйл ажиллагааных нь үндсэн хандлагыг тодорхойлдог үзэл бодол чиг баримжааг агуулж байдгаараа ялгаатай юм
 Д. Нийгмийн доторх олон янзын хэсэг бүлэг, янз бүрийн эрх ашиг бүхий хүчнүүдийг хооронд нь ойртуулан нягтруулж, төрийн нэгдмэл чанарыг хангаж байдгаараа ялгаатай юм
 Е. Энэ нэг ойлголтыг хоёр янзаар тайлбарласан боловч ижил утгатай юм

43. Монгол улсын Төв банк нь тайлангаа хаана гаргах вэ? (1 оноо)
 А. Дээд шүүхэд В. Засгийн газарт С. УИХ-д
 D. Сангийн яаманд E. Хэнд ч тайлагнахгүй
44. Татвар тооцох, ноогдуулах журмыг зөв харгалзуулна уу. (3 оноо)
 1. Декларацийн арга а. Цалин, хөдөлмөрийн хөлс, ноогдол ашиг, хадгаламжийн хүүгийн орлогод татвар ноогдуулахад тухайн орлогыг олгож байгаа байгууллага хэрэглэх арга
 2. Кадастрын арга б. Гол төлөв газар, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтөлж, тэдгээрт хөрөнгийн татвар ноогдуулах журам
 3. Суутгалын арга с. Татвар төлөгч тодорхой хугацаанд олсон орлогоо татварын албанд тусгай маягтаар мэдэгдэх
 А. 1b 2c 3a В. 1c 2b 3a С. 1c 2a 3b
 D. 1b 2a 3c E. 1a 2b 3c
45. Шашны нийгмийн үүргийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
 А. Үнэт зүйлийн үүрэг
 В. Зохицуулах болон хэм хэмжээний үүрэг
 С. Хүмүүсийг нэгтгэх, туслалцаа үзүүлэх үүрэг
 D. Ертөнцийг үзэх үзлийн үүрэг
 E. Амьдралын баталгааг хангах үүрэг
46. Оюуны соёлд хамааралгүй өгөгдлийг ол. (1 оноо)
 А. Эрдэм шинжилгээний хүрээлэн В. Сургууль С. Театр
 D. Номын сан E. Аль нь ч биш
47. Соёлын нэвчих үзэгдлийн сувгуудыг тоочихдоо хамаарахгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
 А. Цагаачлал В. Жуулчлал С. Худалдаа
 D. Үйлдвэрлэл E. Дайн
48. Манай улс социалист хөгжлийн замд орсныг гэрчлэх баримт бичиг аль нь вэ? (1 оноо)
 А. 1924 оны үндсэн хууль В. 1940 оны үндсэн хууль С. 1960 оны үндсэн хууль
 D. 1992 оны үндсэн хууль E. Зөв хариулт алга
49. Зах зээлийн төрлүүдийг зөв харгалзуулна уу. (3 оноо)
 1. Чөлөөт өрсөлдөөний зах зээл а. Нэгэн төрлийн бүтээгдэхүүн олон, үнийг зах зээл тодорхойлно
 2. Олигополь б. Нэгэн төрлийн бүтээгдэхүүн олон, үнийн манлайлах нөлөө байдаг
 3. Монопольт өрсөлдөөн с. Ялгавартай бараа үтээгдэхүүнтэй, үнийн нөлөөлөл хязгаарлагдмал
 А. 1a 2b 3c В. 1a 2c 3b С. 1b 2c 3a
 D. 1b 2a 3c E. 1c 2a 3b
50. Хуйвалдаан ямар зах зээл дээр үүсэх боломжтой вэ? (1 оноо)
 А. Төгс өрсөлдөөнт зах зээл В. Монопольт өрсөлдөөнт зах зээл
 С. Олигополь зах зээл D. Монопользах зээл
 E. Ямар ч зах зээл дээр үүсэхгүй
51. Дэлгүүрт үхрийн махны үнэ өссөн учир Батаа хонины мах худалдан авсан бол зах зээл дээрх хандлага. (1 оноо)
 А. Орлуулах шинжтэй барааны эрэлт өсөх В. Хавсрах шинжтэй барааны эрэлт өсөх
 С. Хонины мах гиффен бараа болох D. Үхрийн мах доорд бараа болох
 E. Дээрх бүгд зөв
52. Ямар соёлыг үндэсний, шашны, мэргэжлийн гэж ангилдаг вэ? (1 оноо)
 А. Зонхилогч соёл В. Сөрөг соёл С. Дэд соёл
 D. Аль нь ч биш E. Ардын соёл
53. Анх цөөн тооны улс орны эрх ашгийг илэрхийлсэн цэргийн эвсэл байсан бол 1990-ээд оноос өөрийн зорилгоо өөрчилж, “Энхийн төлөө түншлэл” хөтөлбөрийг боловсруулж, дэлхийн энх тайвны төлөө ажиллах болсон олон улсын байгууллагыг нэрлэнэ үү? (1 оноо)
 А. НҮБ В. Дэлхийн банк С. НАТО
 D. АПЕК E. ШХАБ
54. Монгол улсаас “Дэлхийн утга соёлын шилдэг өвийн дээжис”-д нэр дэвшүүлсэн урлагийн төрөлд хамаарагдахгүйг ол. (2 оноо)
 А. Хөөмий Б. Уртын дуу С. Морин хуур
 D. Тууль E. Уран нугаралт

55. Төрийн хөгжлийн аль үе шатанд хүмүүсийн нийтлэг зөвхөн цусан төрлийн холбоон дээр суурилахаа больж нутаг дэвсгэр угсаатны нийтлэгүүд бий болон улмаар эрх мэдлийн эх сурвалж нь зөвхөн удирдагчийн онцгой авьяас чадвар байхаа больж уламжлах, үе залгамжлах ёс зэрэг өөр хүчин зүйлээр тодорхойлогдох болсон бэ? (1 оноо)
- A. Хөгжлийн эхэн үе
B. Эртний Грек, Ромоос дундад зууныг дуусах хүртэлх үе
C. Орчин үед
D. Хүй нэгдлийн байгууллын үед
E. Овгийн байгууллын үед
56. Нийгмийн давхраажилтын хэмжигдэхүүнд үл хамаарах зүйл дурдсан бол аль нь вэ? (1 оноо)
- A. Эд баялаг
B. Эрх мэдэл
C. Нэр хүнд
D. Боловсрол
E. Гэрлэлт
57. Эртний нэгэн сэтгэгч “Миний төр намайг хамгаална” гэж хэлсэн байдаг. Тэгвэл энэ нь төрийн хувьд дараах үүргүүдийн алинд нь хамаарах вэ? (1 оноо)
- A. Хүлээсэн үүрэг
B. Социаль үүрэг
C. Зайлшгүй үүрэг
D. Төрийн ёс зүйн асуудал
E. Заяагдмал үүрэг

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Нийгмийн зарим институтын чиг үүргийг харгалзуул. (5 оноо)

1.	Гэр бүлийн	A.	Хоол хүнс, хувцас хэрэглэл, байр, орон сууцаар хангагдах
2.	Эдийн засгийн	B.	Сүм хийдийн харилцаа дэг ёст үйлчлэх, шүтлэг бишрэлийг гүнзгийрүүлэх
3.	Улс төрийн	C.	Хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, халамжлах
4.	Шашны	D.	Хүмүүсийг нийгэмшүүлэх ба суурь үнэт зүйл, дадлага практикт суралцуулах
5.	Боловсролын	E.	Хууль дүрэм ба хэм хэмжээнүүдийг дэмжих

- 2.2. Төрийн үүсэл гарлыг дараах эрдэмтэд өөрсдийн үзэл баримтлалын үүднээс харилцан адилгүй тайлбарласан байдаг. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? (5 оноо)

1.	Шашны онол	A.	Классен, Фрейд
2.	Эцгийн эрхт ёсны онол	B.	Августин, Аквинский
3.	Нийгмийн гэрээний онол	C.	Аристотель, Фильмер
4.	Нийгмийн эдийн засгийн онол	D.	Платон, Симон
5.	Улс төрийн антропологийн онол	E.	Гроций, Спиноза

- 2.3. Олон улсын харилцааны онолуудыг зөв харгалзуулна уу. (4 оноо)

- A. Идеализм
1. Олон улсын харилцаанд улсууд, олон улсын байгууллагууд, үндэстэн дамнасан аж ахуй, олон нийтийн бүтцүүд идэвхтэй оролцох болсон бөгөөд өөр хоорондоо нягт холбогдсон харилцан хамааралтай байна гэж үздэг
- B. Реалист
2. Мөргөлдөөныг багасгах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үндэстнүүдийн хоорондын харилцааг нэмэгдүүлэхэд анхаарсан
- C. Плюрализм (глобализм)
3. Пролетарийн хувьсгал хийж дэлхий дээр үндэстэн, үндэстэний улс үгүй болно. Олон улсын харилцаа бол баян, ядуугийн тэнцэл юм гэж үзсэн
- D. Марксизм
4. Олон улсын харилцааны мөн чанар бол тусгаар улсуудын өөрийгөө хамгаалах, сонирхолоо хэрэгжүүлэх эрмэлзэл, өрсөлдөөн, хүчний тэнцвэр гэж үзсэн

ХУВИЛБАР В

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Анх социологи хэмээх нэр томъёог хэрэглэн, нийгмийг шинжлэх ухааны үүднээс судлах зорилгыг хэн дэвшүүлсэн бэ? (1 оноо)
 А. Ж.Руссо В. О.Конт С. Платон
 Д. Т.Гоббс Е. Ж.Локк
2. Монголчуудын “Төрийн минь сүлд өршөө” гэж залбиран төрөө дээдлэх явдал нь аль легитим шинжийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
 А. Харизмат В. Хууль ёсны С. Үзэл суртлын
 Д. Уламжлалт Е. Ангийн
3. Нийгмийн нэг анги давхраанаас дээшлэх юм уу, доошлох шилжилтийг юу гэдэг вэ? (1 оноо)
 А. Босоо чиглэлт В. Хэвтээ чиглэлт С. Үе хоорондын
 Д. Үе доторх Е. Хувийн
4. Түүхэн явцад бүрэлдэн тогтсон хүмүүсийн томоохон тогтвортой хамтлаг, нийтлэгүүдийн зүй зохистой, зорилго чиглэлтэй, зохион байгуулагдсан хамтын үйл ажиллагааны цогц үр дүн гэсэн нь доорх өгөгдлөөс алийг нь илүү илэрхийлж байна вэ? (1 оноо)
 А. Нийгэм В. Үндэстэн С. Ард түмэн
 Д. Угсаатан Е. Энэ гурваас өөр нэгдэл
5. Хүн төрөлхтний түүхэнд төргүй үе байсан. Хүмүүс аль үед төргүйгээр амьдарч байсан бэ? (1 оноо)
 А. Хүй нэгдлийн байгууллын үед В. Дундад зууны үед
 С. Хүн төрөлхтний хөгжлийн дунд үед Д. Тийм үе байгаагүй
 Е. 13-р зууны үед
6. Нийгмийн хөгжлийг байгалийн хүчин зүйлээр тайлбарлах үзэл хандлагуудад аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)
 А. Газар зүйн үзэл В. Биологийн сургаал С. Сэтгэл зүйн сургаал
 Д. Хүн ам зүйн сургаал Е. Байгалийн шалгарлын хууль
7. Гэр бүлийн доторх хэв маяг, ханиа сонгох ёсыг зөв харгалзуул. (2 оноо)
 1. Эцгийн эрхт ёс а. Гэрлэлтийг тодорхой бүлгийн хүрээнд нь баталгаажуулдаг ёс
 2. Эхийн эрхт ёс б. Гэрлэлтийг тодорхой бүлгээс нь үл хамааруулан зохицуулдаг ёс.
 3. Экзогами ёс с. Гэр бүлийн гишүүдийг эрэгтэй хүн удирдаж засаглах байдал
 4. Эндогами ёс d. Гэр бүлийн засаглалын тогтолцоонд эхнэр юмуу эх голлон үүрэгтэй оролцох
 А. 1с 2d 3b 4a В. 1a 2b 3с 4d С. 1b 2с 3d 4a
 Д. 1с 2a 3b 4d Е. 1с 2b 3a 4b
8. Ухамсар сэтгэхүйн чанарууд тухайлбал зөгнөж мөрөөдөх, дурсан санах, дүгнэлт хийх гэх мэт нь хүнийюм. (1 оноо)
 А. Биологийн мөн чанар В. Нийгмийн мөн чанар С. Оюуны мөн чанар
 Д. Байгалийн мөн чанар Е. Зөн совин
9. Хууль зүй ба зан заншлаар тогтоогдсон, эрх үүргээ өв залгамжлан уламжлах нийгмийн бүлгийн хэв маягийг гэнэ. /Нөхнө үү/ (2 оноо)
 А. Боолчлол В. Кастын хэв маяг С. Язгуур угсааны хэв маяг
 Д. Хаалттай хэв маяг Е. Тэгш бус байдал
10. Аль нь зөв бодомж вэ? (2 оноо)
 А. Нийгэмшилт бол хүмүүсийн хоорондын хамтач шинж мөн
 В. Нийгэмшилт бол хүн өөрийгөө нийгмийн эрх ашигт захируулахуй мөн
 С. Нийгэмшилт бол хүн өөртөө анхаарал тавих явдал мөн
 Д. Нийгэмшилт бол тухайн хүн их хөдөлмөрлөх явдал мөн
 Е. Нийгэмшилт бол хүн хэрэгцээгээ хангах үйл явц мөн
11. Аль бодомж нь зөв бэ? (2 оноо)
 А. Санкци нь тодорхой хүрээ цаг хугацаанд мөрдөгдөх дүрэм
 В. Санкци нь байнга дагаж мөрдөж байх ерөнхий дүрэм
 С. Санкци нь зөвхөн эерэг үнэлэмжтэй
 Д. Санкци нь эерэг ба сөрөг үнэлэмжтэй
 Е. Санкци нь нь зөвхөн сөрөг үнэлэмжтэй

12. Аль нь орчин үеийн нийгмийн шинж вэ? (2 оноо)
 А. Хөдөлмөрийн хуваарь, төрөл мэргэжил нь байгалийнх байдаг
 В. Хувь хүмүүсийн хооронд албан биш хувийн харилцаа давамгайлдаг
 С. Хүмүүсийн харилцаа нь ёс заншил, зан үйлд тулгуурладаг
 Д. Удирдлагын болхи системтэй
 Е. Удирдлагын нийлмэл систем бий болсон
13. ОХУ-ын Ерөнхий сайд В.Путин Монгол улсад албан ёсны айлчлал хийв. Энэ нь нийгмийн харилцааны аль түвшинд хамаарах вэ? (1 оноо)
 А. Бие хүмүүсийн хоорондын харилцаа
 В. Бүлэг, нийтлэгийн хоорондын харилцаа
 С. Институт хоорондын харилцаа
 D. Нийгэм хоорондын харилцаа
 Е. Бие хүн, бүлэг нийтлэгийн хоорондын харилцаа
14. Тухайн нутаг дэвсгэр дээрх юмуу бүлгийн бүх хүнийг хамруулахгүйгээр харин тодорхой төлөөллийн үзүүлэлтүүдийг сонгон судлах нь юм. /Нөхнө үү/ (1 оноо)
 А. Анкетын арга
 В. Түүврийн арга
 С. Ажиглалтын арга
 D. Индукцийн арга
 Е. Дедукцийн арга
15. Үл мэдэх ба мэдэж болохгүй зүйлст хариулт өгөх, нийгмийн эв нэгдэл, зөвшилцөл тогтоох хэрэгцээг нийгмийн аль институт хангах вэ? (1 оноо)
 А. Гэр бүлийн институт
 В. Боловсролын институт
 С. Улс төрийн институт
 D. Эдийн засгийн институт
 Е. Шашны институт
16. Аль нь уламжлалт нийгмийн шинж биш вэ? (1 оноо)
 А. Хөдөлмөрийн хуваарь, төрөл мэргэжил нь байгалийнх байдаг
 В. Хувь хүмүүсийн хооронд албан биш хувийн харилцаа давамгайлдаг
 С. Хүмүүсийн харилцаа нь ёс заншил, зан үйлд тулгуурладаг
 D. Удирдлагын болхи системтэй
 Е. Удирдлагын нийлмэл систем бий болсон
17. Хүмүүсийн амьдралын наад захын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн бодлого явуулах зорилго бүхий төрийн хэв маягийг ... гэнэ.
 А. Төрийн хэлбэр
 В. Эрх зүйт төр
 С. Социал төр
 D. Төрийн дэглэм
 Е. Төрийн байгууламжийн хэлбэр
18. Платон, Аристотель нар Төрийг ангилах анхны оролдлого хийхдээ, ямар шалгуурыг үндэс болгосон бэ? (1 оноо)
 А. Эрх мэдлийг хэн хэрэгжүүлж буйг үндэс болгосон
 В. Өөрчлөлт хөгжилтийн онцлогийг үечлэн тодорхойлох ерөнхий хандлагад тулгуурласан
 С. Материаллаг үйлдвэрлэлийн хөгжлийн үе шатанд тулгуурласан
 D. Иргэншлийн онол, арга зүйг үндэслэн
 Е. Төрөөс эрх мэдлээ хэрэгжүүлэх аргаар нь
19. Бодит дэмжлэгт аль нь хамаарахгүй вэ? (1 оноо)
 А. Татвар төлөх
 В. Цэргийн алба хаах
 С. Эд материалын дэмжлэг үзүүлэх
 D. Төрийн бэлгэдлийг хүндэтгэн үзэх
 Е. Сонгуульд саналаа өгөх
20. Монгол улсын үндсэн хуулийн 20-р зүйлд, "... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгална" гэсэн нь илэрхийлнэ. (1 оноо)
 А. Улс төрийн засаглалыг
 В. Улс төрийн дэглэмийг
 С. Нийтлэг эрх ашгийг
 D. Төрийн удирдлагын хэлбэрийг
 Е. Төрийн бүрэн эрхийг
21. Төрийн чиг үүргийг зөв харгалзуулаарай. (3 оноо)
 1. Төрийн чиг үүрэг
 а. Нийгмийн амьдралын хүрээнд төрөөс заавал гүйцэтгэх ёстой эрх зүйн болон зохион байгуулалтын үйл ажиллагааны үндсэн чиглэл
 2. Төрийн дотоод чиг үүрэг
 b. Улс орноо батлан хамгаалах
 3. Төрийн гадаад чиг үүрэг
 c. Төрийн болон нийгмийн аюулгүй байдлыг хангах
 А. 1a 2c 3b
 В. 1c 2a 3b
 С. 1c 2b 3a
 D. 1a 2b 3c
 Е. 1b 2a 3c
22. Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээний механизм аль нь вэ? (1 оноо)
 А. АСЕАН
 В. АСД
 С. АПЕК
 D. АРФ
 Е. ОПЕК

23. Элитийн засаглалын хүч чадал, гол эх сурвалж нь дотоод зохион байгуулалт, эв нэгдэл хэмээн үзсэн эрдэмтэн аль нь вэ? (2 оноо)
 А. Г.Моска В. Д.Истон С. М.Вебер
 D. Г.Алмонд E. К.Маркс
24. Оролцооны дэмжлэгийн жишээ аль нь вэ? (1 оноо)
 А. Татвар төлөх В. Цэргийн алба хаах С. Эд материалын дэмжлэг үзүүлэх
 D. Төрийн бэлгэдлийг хүндэтгэн үзэх E. Сонгуульд саналаа өгөх
25. Монгол улсад шүүх засаглалыг хэрэгжүүлэх байгууллага нь юм. (2 оноо)
 А. Шүүх В. Прокурор С. Үндсэн хуулийн цэц
 D. А, В, С хариулт зөв E. Зөвхөн А ба В хариулт зөв
26. Сонгуулийн хэмжээс буюу босго тогтоох арга хэрэглэн босгыг сонгогчдын тооноос хамааруулан тойрог бүрт янз бүр байхаар, эсхүл улсын хэмжээгээр нэг адил байхаар тогтоодог нь сонгуулийн аль систем бэ? (2 оноо)
 А. Мажоритар В. Пропорциональ С. Холимог
 D. Сонгуулийн систем E. Суудал хуваарилах
27. Ядуучууд бусдаас хэр зэрэг доогуур амьдарч байгааг харуулах үзүүлэлт бөгөөд тодорхой хэмжээний хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нөхцлийг ... гэнэ. (1 оноо)
 А. Хүнс тэжээлийн ядуурал В. Хэрэгцээний ядуурал С. Үнэлгээний ядуурал
 D. Харьцангуй ядуурал E. Нэн ядуурал
28. Соёл, ахуйн үйлчилгээ, гоёл чимэглэлийн зүйлс, тансаг эдлэлийн шаардлагыг аль хэрэгцээнд хамааруулах вэ? (2 оноо)
 А. Хэрэгцээ В. Материаллаг хэрэгцээ С. Анхдагч хэрэгцээ
 D. Хоёрдогч хэрэгцээ E. Бүлгийн хэрэгцээ
29. Хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлдөг хүчин зүйлсийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
 А. Ажиллагсдын боловсрол В. Ажиллагсдын урам зориг, сонирхол
 С. Ажиллагсдын гарал, нийгмийн байдал D. Хөдөлмөрийн зохион байгуулалт
 E. Тоног төхөөрөмжийн чанар
30. Нийлүүлэлт нэмэгдвэл (2 оноо)
 А. Үнэ өснө, тоо хэмжээ өснө В. Үнэ буурна, тоо хэмжээ буурна
 С. Үнэ буурна, тоо хэмжээ өснө D. Үнэ өснө, тоо хэмжээ буурна
 E. Тэнцвэрт үнэ тогтоно
31. Хэрэглээний үнийн индексийг хэрхэн тодорхойлдог вэ? (1 оноо)
 А. Тухайн онд авсан сагсны зах зээлийн үнийг суурь жилийн барааны сагсны үнэд харьцуулна
 В. Тухайн онд авсан сагсны зах зээлийн үнийг өмнөх жилүүдийн барааны сагсанд харьцуулна
 С. Инфляцийн түвшний өөрчлөлтөөр тодорхойлно
 D. Тодорхой хугацааны завсар дахь үнийн нийт түвшний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ
 E. Аль алианаар нь тодорхойлж болно
32. Өмч нь эдийн засгийн болоод хууль зүйн ойлголт юм. Доорх өгөгдлөөс аль нь эдийн засгийн талыг илэрхийлэх вэ? (2 оноо)
 А. Өмчийг эзэмших В. Ашиглах С. Бэлэглэх
 D. Арвижуулах E. Худалдах
33. Зах зээлийн харилцаа эдийн засгийн үндсэн үйл явцуудын алин дээр нь илэрдэг вэ? (2 оноо)
 А. Үйлдвэрлэлт В. Хувиарлалт С. Арилжаа
 D. Хэрэглээ E. Түгээлт
34. Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ урьдын адил байхад нэмж ажилчин авч ажиллуулснаар хугацаа хэмнэсэн бол ... (2 оноо)
 А. Хөдөлмөрийн бүтээмж өснө В. Хөдөлмөрийн бүтээмж буурна
 С. Материалын бүтээмж өснө D. Материалын бүтээмж буурна
 E. Ашиг нэмэгдэнэ
35. ... гэдэг нь үйлдвэрлэлийн боломжийг бүрэн дүүрэн хүчин чадалд нь хүргэж ашиглах явдлыг илэрхийлдэг үзүүлэлт юм. (2 оноо)
 А. Үр ашиг В. Ашиг С. Нийт бүтээмж
 D. Хөдөлмөрийн бүтээмж E. Нийт орлого
36. Нийгмийн баялгийн тодорхой хэсгийг шударгаар олж авч өөрийн болгон түүнийгээ мэдэж захиран зарцуулах туйлын эрх эдлэх нь дараах өгөгдлүүдийн алинд нь тохирох вэ? (2 оноо)
 А. Өмч В. Нийтийн өмч С. Төрийн өмч
 D. Хувийн өмч E. Өмч хувьчлал

37. Парламентаас баталж засгийн газар бүрдүүлэн зарцуулдаг мөнгөн хөрөнгийг гэнэ. (2 оноо)
 А. Төсвийн гадуурх улсын сангууд В. Улсын төсөв С. Хүн амын санхүү
 D. Орон нутгийн төсөв E. Байгууллагын төсөв
38. ҮНБ-ийг орлогоор тооцохдоо дараах хариултын алийг нь харгалзахгүй вэ? (2 оноо)
 А. Цалин хөлс В. Түрээс С. Зээлийн хүү
 D. Хэрэглээ E. Ашиг
39. “Өгөөж” ХХК бүтээгдэхүүнээ хорооллын дэлгүүрүүдэд үйлдвэрийнхээ үнээр нийлүүлдэг гэвэл тухайн дэлгүүрүүдийн хувьд бараагаа ямар үнээр зарж борлуулах вэ? (2 оноо)
 А. Үйлдвэрийн үнээр В. Бөөний үнээр С. Жижиглэнгийн үнээр
 D. Нэрлэсэн үнээр E. Биржийн үнээр
40. Хэм хэмжээг даган сахиулахын тулд үзүүлж буй нийгмийн шийтгэл болон урамшууллыг ... гэнэ. (1 оноо)
 А. Хариуцлага В. Санкси С. Нийгмийн хяналт
 D. Нийгмийн дэг журам E. Дэг журам сахиулах үйл явц
41. Наадмаар гадаадын жуулчид Монголд олноор ирдэг нь дараах өгөгдлийн алинаар тайлбарлагдах вэ? (1 оноо)
 А. Соёл универсал шинжтэй В. Бүх хүнд адилхан хэрэгцээ байдаг
 C. Соёлын холбоо D. Соёлын олон талт байдал
 E. Үндэсний соёлын онцлогийг сурталчлах өргөн боломж
42. Хэлний нийгмийн үүргийг тоочихдоо буруу зүйл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
 А. Соёлыг нэг үеэс нөгөө үед дамжуулах В. Соёлыг бүтээх, илгээх
 C. Хүмүүс хоорондоо мэдээлэл солилцох D. Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх
 E. Хэм хэмжээ тогтоох
43. Олон оронд гудамжаар нүцгэн явах, ахмад хүнийг доромжлох, эмэгтэй хүнийг зодох, сул дорой хүмүүсийг гомдоох, тахир дутуу хүмүүсийг даажигнах гэх мэтийн үйлдлийг ёс суртахуунгүй хэмээн үздэг. Энэ нь дараах ойлголтын алинд нь хамаарах вэ? (2 оноо)
 А. Зан үйл В. Ёс заншил С. Зан заншил
 D. Уламжлал E. Зан үйлийн стандарт
44. Болд гэрээсээ гарч яваад хэтэвчтэй мөнгө олов. 100.000 төгрөг байснаас хагасыг нь үржээ. Орой иртэл ах нь хэтэвчээ гээсэн тухай ярьж байв. Болд мөнгийг нь үрсэн тул айгаад юу ч хэлсэнгүй. Болд ямар нэг хэм хэмжээ зөрчсөн үү? (1 оноо)
 А. Эрхийн хэм хэмжээг зөрчсөн В. Шашны ёсыг гажуудуулсан
 C. Ёс суртахууны хэм хэмжээг илүү зөрчсөн D. Улс төрийн хэмжээ зөрчсөн
 E. Хэм хэмжээ зөрчөөгүй
45. Хип хоп урлагийг өсвөр үеийнхэн ихэд таашааж байхад ахмадууд төдийлөн таашаадаггүй нь дараах өгөгдлийн алинаар илүү тайлбарлагдах вэ? (1 оноо)
 А. Соёлын өөрчлөлтийн эх үүсвэр
 B. Соёлын хэм хэмжээ
 C. Субъектээс хамаарч үнэлэмж нь өөр өөр байх
 D. Соёлын олон талт байдал
 E. Нийтийн соёл нь үнэ цэнийн хувьд ардын соёлд хүрдэггүй
46. Оюуны соёлын элементүүдийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
 А. Мэдлэг В. Хэл яриа С. Эрх мэдэл
 D. Домог E. Зан заншил
47. Хүмүүс өөрсдийнхөө янз бүрийн үйл ажиллагааг ивээн тэтгэж байдаг янз бүрийн бурхад оршдог хэмээн сэтгэж олон бурхны тухай хийсвэрлэл гаргаж ирсэн. Энэ нь шүтлэгийн аль хэлбэр вэ? (1 оноо)
 А. Монотеизм В. Политеизм С. Анимизм
 D. Тотемизм E. Фетишизм
48. Сонгодог хөгжим соёлын аль хэлбэрт багтах вэ? (1 оноо)
 А. Нийтийн соёл В. Ардын соёл С. Элитийн соёл
 D. Дэд соёл E. Сөрөг соёл
49. Сонгодог соёлын хэрэглэгчдэд хэн нь хамаарахгүй вэ?
 А. Өндөр боловсрол бүхий шүүмжлэгчид В. Утга зохиол судлаачид
 C. Хүүхдүүд D. Театрынхан E. Дээрх бүгд хамаарна
50. Эзлэгдсэн орны ард түмэнд сүсэг бишрэлээ тулгахаас эхлээд зарим улс оронд “Америк аж төрөх ёс”, “Зөвлөлт аж төрөх ёс”-ыг хүчээр тулгах гэсэн оролдлогууд байсан нь аль үзлийн жишээ вэ? (1 оноо)
 А. Этноцентризм В. Релятивизм С. Универсализм
 D. Диффузи E. Дээрх бүгд

51. Хүйтэн дайны үед дэлхийн бодлого 2 туйлт системээс бүрэлдэж байсан бол 1985 оноос социализм нуран унасан нь хэдэн туйлт системийг бий болгосон бэ? (2 оноо)
 А. Олон туйлт систем В. Хоёр туйлт систем
 С. Нэг туйлт систем D. Хараахан үүсээгүй
 E. Хоёр ба олон туйлт системийн завсрын шинжтэй байсан
52. Монгол улсын гадаад бодлогын үйл ажиллагааг хамрах салбараар нь хэрхэн ангилдаг вэ? (2 оноо)
 А. Улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл-хүмүүнлэгийн
 В. Улс төр, эдийн засаг, боловсрол соёлын, хүмүүнлэгийн
 С. Хоёр талын ба олон талт хамтын ажиллагаа
 D. Бүс нутгийн ба тив дамнасан
 E. Бүс нутгийн, олон улсын, тив дамнасан
53. Аль нь Монгол улсын гадаад бодлогын өнөөгийн зарчим биш вэ? (2 оноо)
 А. Үндэсний эрх ашгийг дээдлэх В. Идэвхтэй
 С. Нээлттэй D. Энх тайвнаар зэрэгцэн орших
 E. Олон тулгуурт
54. 1945 оны 10 сарын 23-нд НҮБ анх ямар шалтгаанаар байгуулагдсан бэ? (2 оноо)
 А. Бие даасан улс орнуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэж эдийн засаг, нийгмийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх, энх тайвныг сахин хамгаалахын төлөө
 В. Шинэ дайны аюулаас сэрэмжлэн хамгаалах, бүх нийтийн энх тайвныг сахин хамгаалах зорилготой
 С. Улс орнуудын эрүүл мэнд хүмүүнлэгийн салбарт тусламж үзүүлэх
 D. Тусгаар тогтносон улс орнуудад эдийн засгийн хөнгөлөлт үзүүлэх
 E. Дээрх хариулт бүгд зөв
55. Гэр бүлийн хэв маягаас аль нь эхнэр, нөхрийн эрх тэгш байдлыг илэрхийлдэг вэ? (1 оноо)
 А. Патриархаль В. Эгалитар С. Матриархаль
 D. Полигами E. Полиандри
56. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. (3 оноо)
 1. Соёлын албан бус хэм хэмжээ a. Бүхий л соёлд нэгэн адил хамаардаг ерөнхий үнэт зүйлс
 2. Соёлын универсал шинж b. Олон түмний санал сэтгэгдлээр дэмжигдэж байдаг сайн мууг тодорхойлогч ерөнхий дүрэм журам
 3. Соёлын өвөрмөц шинж c. Монгол улсын иргэн сонгох, сонгогдох эрхтэй
 4. Албан ёсны хэм хэмжээ d. Араб эмэгтэйчүүд нүүрээ халхалсан гивлүүр зүүдэг
 A. 1a 2b 3c 4d B. 1b 2a 3d 4c C. 1d 2c 3b 4a
 D. 1c 2a 3b 4d E. 1b 2d 3a 4c
57. Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг зөв харгалзуул. (4 оноо)

1.	Европын холбоо	a.	Ази, Европын орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх байгууллага
2.	Зүүн өмнөд азийн орнуудын холбоо /АСЕАН/	b.	Европ тивийн улс түмний нягт холбоог бий болгох, эдийн засгийн тэнцэлтэй байнгын дэвшилд дөхөм үзүүлэх, гадаад болон аюулгүй байдалд нийцсэн бодлого явуулж олон улсын харилцаанд Европын нэгдмэл шинж чанарыг бататгах, нийтлэг өв уламжлалыг хадгалан бэхжүүлэх зорилго бүхий байгууллага
3.	Ази, Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга /АПЕК/	c.	Зүүн өмнөд Азийн эдийн засаг, нийгэм, соёлын салбарт хамтын ажиллагааг зохион байгуулах, энх тайван тогтвортой байдлыг буй болгоход дөхөм үзүүлэх зорилготой байгууллага
4.	Ази-Европын уулзалт /АСЕМ/	d.	Ази, Номхон далайн бүсэд олон талын чөлөөт худалдааны хөрөнгө оруулалтын нээлттэй зах зээл бий болгоход дөхөм үзүүлэх зорилготой байгууллага

A. 1b 2c 3d 4a
 D. 1d 2a 3b 4c

B. 1b 2a 3d 4c
 E. 1c 2d 3b 4a

C. 1c 2d 3a 4b

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дэлхийн олон улсын харилцааны бодлого туйлуудыг тохирох дүрмүүдтэй нь зөв харгалзуулна уу? (5 оноо)

1.	Нэг туйлт	A.	1. Нөгөө хоёр талтай аль алинтай нь сайн харилцаатай байх, зөрчил үүсэхээс болгоомжлох 2. Нөгөө 2 талын хооронд ойр дотны хамтын ажиллагаа бий болохоос сэргийлэх явдал
2.	Хоёр туйлт	B.	1. Ноёрхогч шинжтэй бий болж буй аливаа улс, эвслийг эсэргүүцэх 2. Хүчээ аль болгох ихэсгэх, эсвэл хадгалах 3. Аль нэг талтай дайтсан ч системийг бүхэлд нь тогтворжуулах хэрэггүй.
3.	Гурван туйлт	C.	1. Нэг эвсэлтэй тэмцэлдэх, боломжтой бол устгахыг оролдох 2. Өөрийн хүчийг байнга нэмэгдүүлэхийг оролддог, нөгөө эвсэлийн гишүүнийг өөртөө татах, өөрөөсөө гишүүнээ алдахгүй байх гэх мэт тактик ашиглана.
4.	Олон туйлт	D.	1. Цөм их гүрэн нь үндсэн дүрэм зарчмыг тогтоон хэрэгжүүлж, цэрэг эдийн засгийн хувьд ноёрхоно. 2. Өөрийн нөлөөнд буй нэгжүүдийн хоорондын Зөрчилдөөнийг зохицуулна. 3. Нэгж улсуудыг тусгаарлах, бие даах оролдлогыг таслан зогсоох
5.	Цөөн туйлт	E.	1. Олон улсын харилцаан дахь онолын ойлголт биш

2.2. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

A. Улс төрийн хүлээцтэй байдал	1. Бүх хүнийг ижил боломжтой байлгаж, арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, хүйсээр ялгаварлахгүй
B. Иргэдийн оролцоо	2. Ард түмний олонх улс орныг удирдаж байхад цөөнхийн эрхийг хамгаалсан байх ёстой
C. Тэгш эрх	3. Хүн бүр хуулийг сахина, зөрчвөл хариуцлага хүлээнэ
D. Чөлөөт шударга сонгууль	4. Иргэд өөрсдийнхөө талаар шийдвэр гаргахад идэвхтэй үйл ажиллагаа явуулах, бие даасан байр суурь баримтлах
E. Хуульд захирагдах ёс	5. Төр засагт өөрсдийгөө төлөөлөх албан тушаалтныг ажиллуулах, солих

2.3. Хүний мэдлэгийн тогтолцоонд гарах ахиц дэвшил, өөрчлөлтүүдтэй уялдаад оршин амьдарч буй нийгмийн талаар өгсөн тодорхойлолт, хандлагуудад хүртэл өөрчлөлт орж байдаг. Тиймээс дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулаарай. (5 оноо)

1.	К. Маркс	A.	Нийгэм гэдэг бол бусад хүмүүсийн болон үйл явдалд хандсан нийгмийн бүтээгдэхүүн болдог хүмүүсийн харилцан үйлчлэл юм.
2.	М. Вебер	B.	Нийгмийг бүрдүүлэгч дэд тогтолцоонуудад нь тус бүрдээ бие даан орших боломжгүй бөгөөд харилцан бие биенийхээ хамааралд оршдог.
3.	Т. Парсонс	C.	Нийгэм гэдэг бол нягт хэлхээ холбоонд оршдог элементүүдийн нийтлэг тогтолцоо юм.
4.	Тогтолцооны хандлага	D.	Нийгэм гэдэг бол холбогч эхлэлийн цэг нь хэм хэмжээ ба үнэт зүйлс байдаг хүмүүсийн хоорондын харилцааны цогц юм.
5.	Шалтгаант чанарын хандлага	E.	Нийгэм гэдэг бол хамтын ажиллагааны үйл явцад бүрэлдсэн хүмүүсийн хоорондын харилцааны түүхэн ёсоор хөгжигч юм.

ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгмийн үзэгдлийг зохиомол орчин нөхцөл бүрдүүлэн судалдаг арга аль нь вэ? (1 оноо)
 А. Ажиглалтын арга В. Ярилцлагын арга
 С. Харьцуулалтын арга D. Баримт бичиг судлах арга
 E. Туршилтын арга
2. Аль нь нийгэмшлийн илүү чухал хүчин зүйл вэ? (2 оноо)
 А. Байгаль, газар зүйн орчин В. Гэр бүлийн орчин
 С. Хэвлэл мэдээлэл D. А ба С хариулт
 E. Хиллэж буй улсууд
3. Аль нь орчин үеийн нийгмийн шинж биш вэ? (2 оноо)
 А. Хөдөлмөрийн хуваарь гүнзгий хөгжсөн, мэргэжил нь боловсролтой холбоотой ажлын туршлага дээр тулгуурласан байдаг
 В. Хүмүүсийн хоорондын харилцаа нь үүргийн шинжтэй байдаг
 С. Нийгмийн харилцааг бичигдмэл хууль, гэрээ хэлэлцээр гэх мэт албан ёсны хэм хэмжээгээр зохицуулдаг
 D. Нийгмийн гишүүд нь янз бүрийн нийгмийн бүлэг, давхраа, институтуудын харилцаагаар холбогдсон байна
 E. Хүмүүсийн харилцаа нь ёс заншил, зан үйлд тулгуурласан байдаг
4. Нийгмийг хамгийн ерөнхий утгаар нь хэрхэн ангилдаг вэ? (1 оноо)
 А. Улс орон ба төр В. Соёл ба иргэншил
 С. Хосолмол ба нийлмэл D. Энгийн ба нийлмэл E. Энгийн ба хосолмол
5. Иргэний нийгмийн тухай сонгодог ойлголтыг ямар сэтгэгчид дэвшүүлэн тавьсан бэ? (1 оноо)
 А. Маркс, Энгельс В. И. Кант, Гегель С. Аристотель, Платон
 D. Агваанбалдан, Агваанхайдав E. Монтескье, Декарт
6. Америкийн нийгэмд “хөх цамцтангууд” гэж ямар ангийг нэрлэдэг вэ? (2 оноо)
 А. Дээд анги В. Дунд анги
 С. Ажилчин анги D. Доод анги E. Хотод оршин суугчид
7. Нийгмийн тогтолцоот чанарын талаас үүргийн хандлагын үндсэн ойлголтыг хэн анх “Социологийн үндэслэл” хэмээх бүтээлдээ боловсруулсан бэ? (1 оноо)
 А. Г. Спенсер В. Р. Мертон С. Т. Парсонс
 D. К. Маркс E. Эдгээрээс өөр
8. Төрийн улс төрийн бусад байгууллагаас ялгагдах гол онцлог шинж нь: (1 оноо)
 А. Хамтын шийдвэр гаргадаг В. Удирдагчтай С. Гишүүнчлэлтэй
 D. Албадлага хэрэглэдэг E. Ялгаа байхгүй
9. “Соёл иргэншил мөхдөг шалтгаан нь ардчилалгүй буюу ардчилал урт насалж чадаагүй явдалтай холбоотой байсан” гэж хэн үзсэн бэ? (1 оноо)
 А. Т. Жефферсон В. А. Линкольн С. Ж. Тойнби
 D. У. Черчилль E. Аль нь ч биш
10. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Хувь хүмүүсийн хоорондын өдөр тутмын харилцааны явцад статусаас нь хамааран тодорхой, тогтвортой холбоо тогтох нь юм. (2 оноо)
 А. Нийгмийн харилцаа В. Нийгэм хоорондын харилцаа
 С. Институт хоорондын харилцаа D. Байгууллага, бүлэг, нийтлэл хоорондын харилцаа
 E. Эдгээрээс өөр
11. Өмчийн тэгш бус байдлаар баталгаажсан, өөрөөр хэлбэл, эдийн засгийн ялгаанаас үүсэлтэй, харьцангуй нээлттэй, хувийн байр сууриа өөрчлөх боломжтой, давхраажилтын хэв маяг аль нь вэ? (1 оноо)
 А. Каст В. Боолчлол С. Язгуур
 D. Анги E. Аль нь ч биш
12. Аль бодомж нь зөв бэ? (1 оноо)
 А. Нам бол улс төрийн системийн гол цөм юм
 В. Ард түмэн бол улс төрийн системийн гол цөм юм
 С. Ардчилал бол улс төрийн системийн гол цөм юм
 D. Төр бол улс төрийн системийн гол цөм юм.
 E. Зөв бодомж байхгүй

13. Төсвийн байгууллагын ажилтнууд цалингаа нэмэгдүүлэх талаар Засгийн газарт хандаж шаардлага тавьжээ. Засгийн газраас тэдний цалинг тодорхой хувиар нэмжээ. Гэсэн ч тэд сэтгэл дундуур байгаа бөгөөд хэсэг хугацааны дараа дахин шаардлага тавих төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газраас явуулж буй бодлого, үйл ажиллагаанд сэтгэл дундуур байна. Дээрх өгөгдөлд аль нь хамаарах вэ? (1 оноо)
- А. Оролт
В. Гаралт
С. Дэмжлэг
D. Шаардлага
E. Эргэх холбоо
14. Төрийн засаглал гэсэн ойлголтод үл хамаарахыг ол. (1 оноо)
- А. Монгол Улсын ерөнхийлөгч айл гэр, албан газар болгон морин хуурыг хоймортоо залах тухай зарлиг гаргав
В. УИХ-аас шинэчлэн найруулагдаж батлагдсан “Татварын багц хууль”-иуд 2007 оны I сарын 1-ээс Монгол Улс даяар мөрдөгдөж эхлэв
С. БСШУ-ны сайдын тушаалаар ЕБС-ийн 1 цагийг 40 минутаар тооцох болов
D. Ардчилсан намын дарга Ц.Элбэгдорж намынхаа бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт хийв.
E. Төрийн албан хаагчдын цалинг Засгийн газрын ... дугаар тогтоолоор 20% нэмэв
15. Улс төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас олон түмний түгээмэл эрх ашигт нийцсэн дайчлан гаргах, хуваарилах, зохицуулах, дэмжлэг үзүүлэх чадвар бүхий тасралтгүй үйл явцыг улс төрийн шинжлэх ухаанд гэж үздэг. Зөв хариултыг ол. (1 оноо)
- А. Улс төрийн шийдвэр
В. Улс төрийн бодлого
С. Улс төрийн дэглэм
D. Улс төрийн ухамсар
E. Улс төрийн соёл
16. Унших, бичих, тоолох, үр хүүхэддээ өвлүүлэх, амьдрах орчны зөв төсөөлөл, бие даан сурах, авъяасаа нээх, чадвараа хөгжүүлэх зэрэг ойлголтууд нь нийгмийн аль институтад байдаг вэ? (1 оноо)
- А. Улс төрийн
В. Эдийн засгийн
С. Шашны
D. Боловсрол
E. Аль нь ч биш
17. Аль нь төрийн албаны ангилал вэ? (1 оноо)
- А. Улс төрийн, тусгай, жинхэнэ, үйлчилгээний
В. Улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний
С. Төрийн, шүүх прокурорын, захиргааны, үйлчилгээний
D. Төрийн, хэрэгжүүлэх, тусгай, үйлчилгээний
E. Улс төрийн, гүйцэтгэх, онцгой, үйлчилгээний
18. Нийгмийг тодорхойлох олон хандлагууд байдаг. Тэгвэл олон нийтийн дүрэм нийгмийн үнэт зүйлс, зан төлвийг задлан шинжлэхэд хэрэглэдэг хандлагыг өгөгдлөөс ол. (1 оноо)
- А. Хүн ам зүйн хандлага
В. Сэтгэл зүйн хандлага
С. Хамт олны хандлага
D. Соёл судлалын хандлага
E. Эдгээрээс өөр хандлага
19. 1206-1921 он хүртэлх монголын нийгмийг давхраажилтын хувьд язгуурын хэв маягтай байсан гэж судлаачид үздэг. Тэгвэл энэ үеийн нийгмийн давхрааны бүтцийг тоочихдоо илүү зүйл дурьдсан бол аль нь вэ? (1 оноо)
- А. Лам нар
В. Малчид
С. Чөлөөт тариачид
D. Хаан, тайж, язгууртнууд
E. Илүүц зүйл байхгүй
20. Улс орныг Нэгдмэл улс, Холбооны улс гэж ангилсан нь юуг үндэслэсэн бэ? (1 оноо)
- А. Төрийн засаглалын хэлбэр
В. Төрийн байгууламжийн хэлбэр
С. Улс төрийн дэглэмийн шинж
D. Улс төрийн засаглалын хэлбэр
E. Төрийн засаглалын хэв маяг
21. Аль нь зөв бэ? (1 оноо)
- А. Иргэний нийгэм бол төрийн байгууллагуудын нийлбэр цогц юм
В. Иргэний нийгэм бол нийгэм дэх төрөөс хараат бүх харилцаа юм
С. Иргэний нийгэм бол төр өөрийгөө илэрхийлэх хүрээ юм
D. Иргэний нийгэм бол төрийн үүрэг оролцоо их байдаг нийгэм юм
E. Иргэний нийгэм бол иргэд нь төрийн эрх мэдлийг хянаж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалж чаддаг нийгэм юм
22. “Ардчилал нь ард түмний тусын тулд тэдний өөрсдийнх нь бий болгосон засаг юм. Өөрөөр хэлбэл, ардчилал бол ард түмний засаглал юм” гэж хэн тодорхойлсон бэ? (1 оноо)
- А. Т.Жефферсон
В. А.Линкольн
С. Ж.Тойнби
D. У.Черчилль
E. Аль нь ч биш
23. Ирээдүйн зорилгодоо хүрэхийн тулд хүмүүсийн хэрэгцээ, сонирхлыг мэдэрч, тэдгээрийг ашиглан хүмүүст итгэл, үнэмшил төрүүлэхийг хичээдэг хошуучлагч аль нь вэ? (1 оноо)
- А. Туг баригч хошуучлагч
В. Худалдаачин хошуучлагч
С. Үйлчлэгч хошуучлагч
D. Гал унтраагч хошуучлагч
E. Хошуучлагч

24. Нийгмийн хөгжилд хүн амын тоо, хүнс тэжээлийн нөөц чухал үүрэгтэй гэж үзсэн эрдэмтнийг нэрлэнэ үү.
(1 оноо)

A. Л.Н.Гумилев B. Мальтус C. Г.Спенсер
D. Демокрит E. У.Беджгот

25. “Улс төр бол аливаа хувьсгалт намын практик үйл ажиллагааны эхлэх цэг бөгөөд тэрхүү үйлдэл ажиллагааны явц ба эцсийн үр дүнгээр илэрдэг.” гэсэн тодорхойлолтыг дүгнэж үзвэл ямар шинж чанарыг агуулсан байна вэ?
(3 оноо)

A. Улс төрийг ёс зүйн үүднээс тодорхойлсон
B. Улс төрийг практик талаас нь тодорхойлсон
C. Улс төрийг зүүний үзэл баримтлалын өнцгөөс тодорхойлсон
D. Улс төрийг барууны үзэл баримтлалын талаас тодорхойлсон
E. Улс төрийг институтийн онолоор тодорхойлсон

26. Орчин үеийн бүгд найрамдах төрийн ангиллын үндсэн шалгуур аль нь вэ?
(2 оноо)

A. Төр засгийг хэн байгуулж, төр хэний өмнө хариуцлага хүлээж буй байдал
B. Засгийн газрыг хэн байгуулж, засгийн газар хэний өмнө хариуцлага хүлээж буй байдал
C. Онцгой эрх мэдэл бүхий хэсэг төрийг удирдаж буй эсэх
D. Парламентыг хэн байгуулж, тэр нь хэний өмнө хариуцлага хүлээж буй байдал
E. Төрийн өндөрлөгүүдийг бүрдүүлэх үйл ажиллагааны чиг хандлага

27. Адам Смитын “Үл үзэгдэх гар” гэдэг нь юуны тухай ойлголт вэ?
(1 оноо)

A. Өрсөлдөөн B. Монополь C. Эрэлт
D. Нийлүүлэлт E. Зах зээл

28. Эдийн засгийн шинжлэх ухааны гол үүргийг тодорхойл
(1 оноо)

A. Эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах
B. Эдийн засгийн үйл ажиллагааг зохион байгуулах
C. Эдийн засгийн үйл ажиллагааг шийдвэрлэх
D. Эдийн засгийн үйл ажиллагааны талаар таамаглал дэвшүүлэх
E. Эдгээрээс өөр

29. Чи хурд сайтай хамгийн сүүлийн үеийн компьютер авах санхүүгийн боломжтой. Гэвч чамд чиний хүссэн компьютер олдохгүй байна. Үүнийг эдийн засгийн ухаанд юу гэж тодорхойлдог вэ?
(1 оноо)

A. Эрэлт B. Хүсэл
C. Хэрэгцээ D. Сонирхол
E. Хүслээ хэрэгжүүлэх бэлэн байдал

30. Мөнгө ямар нөхцөлөөс болж үүссэн бэ?
(1 оноо)

A. Барааг мөнгөөр солиход B. Мөнгөний ханш тогтооход
C. Барааг хэмжиж тоолоход D. Бараа солилцооны ханш тогтооход
E. Барааг бараагаар солилцох үед

31. Ажилгүйдлын түвшин юуг илэрхийлдэг вэ?
(1 оноо)

A. Ажилгүй хүмүүсийн тоог илэрхийлнэ
B. Ажиллах хүчний дотор ажилгүйчүүдийн эзлэх хувийг илэрхийлнэ
C. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхэлж байгааг илэрхийлнэ
D. Ажил хийхийг хүсч идэвхтэй ажил хайж байгаа хүмүүсийг хэлнэ
E. Ажил олговч ажил хийдэггүй хүмүүс

32. Доорх өгөгдлөөс макро эдийн засгийн судлах ойлголтыг ол.
(1 оноо)

A. Хэрэглэгч ба үйлдвэрлэгчийн онол B. Үйлдвэрлэлийн хэрэгсэл, ажиллах хүч
C. Үнэт цаас, мэдээллийн зах зээл D. Зах зээлийн үнэ бүрдэлт
E. Улсын мөнгөн гүйлгээнд өөрчлөлт оруулах

33. Доорх өгөгдлөөс үйлдвэрлэлийн уламжилсан хүчин зүйлийг ол.
(1 оноо)

A. Байгалийн нөөц B. Газрын баялаг
C. Усны эрчим хүч D. Газар
E. Тоног төхөөрөмж

34. Хөдөлмөрийн зах зээл дээр ажилгүйдэл ямар үед их өсдөг вэ?
(1 оноо)

A. Ажил хайгч хүмүүсийн тоо ажлын байрнаас их үед
B. Ажил хайгч хүмүүсийн тоо ажлын байрнаас бага үед
C. Ажил хайгч хүмүүсийн тоо ажилтай хүмүүсээс их
D. Ажил хайгч хүмүүсийн тоо ажилтай хүмүүсээс бага
E. Ажил хайгч хүмүүсийн тоо ажлын байр тэнцвэртэй тохиолдолд

35. 10000 төгрөгийн өртөг нь юу вэ? (1 оноо)
 А. Хэвлэгдсэн тусгай цаасны өртөг
 В. Алтан баталгааны өртөг
 С. Хэвлэхэд зарцуулсан хөдөлмөрийн өртөг
 D. 10000 төгрөгөөр авч болох бараа үйлчилгээний өртөг
 E. Эдгээрээс өөр
36. Тухайн улсын зөвхөн нэг жилд үйлдвэрлэн бий болгосон материал баялгийн хэмжээг . . . гэнэ. (1 оноо)
 А. Дотоодын нийт бүтээгдэхүүн
 В. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн
 С. Үндэсний орлого
 D. Үндэсний нийт бүтээгдэхүүн
 E. Дотоодын цэвэр бүтээгдэхүүн
37. 2008 оны эхээр Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь төрийн зүгээс эдийн засгийг тогтворжуулахаар хэрэглэсэн ямар арга хэмжээ вэ? (1оноо)
 А. Ажилгүйдлийг бууруулах
 В. Орлого дахин хуваарилах
 С. Инфляцийг барих
 D. Ядуурлыг бууруулах
 E. Төсвийн алдагдлыг багасгах
38. Ажил эрхлэлтийн төвшин юуг илэрхийлдэг вэ? (1оноо)
 А. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил хийхгүй байгааг
 В. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил хийж байгааг
 С. Ажил хийхийг хүсч, ажил идэвхитэй хайж байгаа хүмүүсийг
 D. Ажиллах хүчний дотор ажилгүйчүүдийн эзлэх хувийг
 E. Ажилгүйчүүд ба ажилтай хүмүүсийн тооны нийлбэрийг
39. Доорх өгөгдлөөс татварын орлогод багтах “Орлогын албан татвар”-ын зөв өгөгдлийг ол. (1 оноо)
 А. Нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж
 В. Үл хөдлөх эд хөрөнгийн татвар
 С. Аж ахуйн нэгжүүд өөрийн ашгаасаа төлөх татвар
 D. Архи, тамхи, суудлын авто машин, авто бензин
 E. Улсын тэмдэгт, агнуурын нөөц ашигласан, ашигт малтмал зэрэг
40. Монгол Улсын нутаг дээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын үйлдвэрүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдхүүн манай улсын ДНБ-нд тооцогдох уу? (1 оноо)
 А. Гадаадын хөрөнгө оруулалттай тул тооцогдохгүй
 В. Хамтын хөрөнгө оруулалттай тул тооцогдохгүй
 С. Тухайн компани өөрийн орондоо тооцогдоно
 D. Манай улсын ДНБ-нд тооцогдоно
 E. Эдгээрээс өөр
41. Төрөөс авч явуулсан эдийн засгийн арга хэмжээ, түүний зорилгын зөв харгалзааг тогтооно уу. (3 оноо)
 1. Байгууллагуудын төсөвт төлөх ёстой татварын өрийг хүчингүй болгохоор “Татварын өршөөлийн хууль” батлах
 А. Далд эдийн засаг ил гарах, бизнес эрхлэгчдийн ачааллыг хөнгөлөх, техник технологийн шинэчлэлт хийх, хөрөнгө оруулалт нэмэгдэх
 2. Төсөвт байгууллагын ажилчдын цалинг нэмэх
 В. Ажилчдын цалин нэмэгдэх бодит боломж нээгдэх
 3. Байгууллагын хариуцан төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийг 19 хувиас 11 хувь болгож бууруулах
 С. Хүмүүсийн худалдан авах чадвар дээшилж өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэх
 А. 1A2B3C
 В. 1A2C3B
 C. 1B2A3C
 D. 1B2C3A
 E. 1C2A3B
42. Нэг хүнд ноогдох үндэсний орлого нь харьцангуй өндөр мөртлөө тухайн улсын хөгжил сул байгаа нь юутай холбоотой вэ? (2 оноо)
 А. Хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого
 В. Татварын бодлого
 С. Гадаад дотоод худалдааны бодлого
 D. Мөнгөний бодлого
 E. Засгийн газрын зардал
43. Цалин хөлс өрхийн орлогын ихэнхийг бүрдүүлдэг. Хүний хөдөлмөрийг ашигласны төлөө түүний тоо чанарт нийцүүлэн төлөх мөнгөн төлбөрийг цалин хөлс гэнэ. Тэгвэл ямар цалингийн хэмжээ орлогын ерөнхий түвшинг харуулах боловч хүний амжиргааны түвшинг харуулдаггүй вэ? (2 оноо)
 А. Бодит цалин
 В. Цагаар олгох
 С. Нэрлэсэн цалин
 D. Хийснээр олгох цалин
 E. Эдгээрээс өөр

44. ҮНБ-ийг хэмжиж тодорхойлоход холбогдох өгөгдлийг ол. (2 оноо)
 А. Үр тарианы аж ахуйгаас нийлүүлсэн түүхийн эдийн үнэ
 В. Дэлгүүрт борлогдох талхны үнийн хэмжигдэхүүн
 С. Гурилын үйлдвэрт худалдсан үр тарианы үнэ
 D. Өмнөх жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ
 E. Эдгээрээс өөр
45. Төгс өрсөлдөөнт зах зээл дээр пүүсүүд үнэд яагаад нөлөөлж чаддаггүй вэ? (2 оноо)
 А. Бараа үйлчилгээний үнэ хоорондоо ижил учир
 В. Пүүсүүд үнээ өөрчлөвч ашиггүй тул үнэ өөрчлөх сонирхол байдаггүй
 С. Пүүсүүдийн үнэд засгийн газар хяналт тавьдаг
 D. Тухайн нэг пүүсийн зах зээлд эзлэх байр суурь бага
 E. Бараа үйлчилгээний үнэ хоорондоо адил биш учир
46. Монгол улсад сүүлийн хэдэн сар гурилын үнэ огцом өссөнөөс зүссэн талхны эрэлт эрс багассан байна. Яагаад? (3 оноо)
 А. Хослон хэрэглэгддэг бараанууд тул гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид талх авах нь багассан
 В. Гиффен бараанууд тул гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид талх авах нь багассан
 С. Гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид арай хямдаар нь зүсээгүй талхыг авах нь ихэссэн
 D. Орлох бараанууд тул гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид арай хямдаар нь зүсээгүй талхыг авах нь ихэссэн
 E. Дээрх тодорхойлолтууд бүгд буруу
47. Бүтээсэн эзэн нь тодорхой биш, авъяастнуудын бүтээсэн соёлыг юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
 А. Элитийн соёл В. Ардын соёл С. Зонхилогч соёл
 D. Дагуу соёл E. Нийтийн соёл
48. Өгөгдлийг зөв харгалзуул. (3 оноо)
 1. Ядуус a. Амьдралын наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй байдал
 2. Нэн ядуу b. Төрөөс тогтоосон амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд
 3. Үнэмлэхүй ядуурал c. Өрхийн нэг хүнд оногдох орлого нь амжиргааны доод түвшний 40%-д хүрэхгүй байх
 4. Харьцангуй ядуурал d. Амьдралын боломжийн жишиг гэж тухайн нийгмийн үзэж байгаа зүйлсийг хангах чадваргүй байдал
 A. 1b 2c 3a 4d B. 1c 2a 3d 4b C. 1b 2a 3c 4d
 D. 1a 2b 3c 4d E. 1d 2a 3c 4b
49. Төсөөлөл, үнэт зүйл, мэдлэг, үзэл суртал, хэл яриа, оюуны үйлдвэрлэл ямар соёлд багтах вэ? (2 оноо)
 А. Материаллаг соёл В. Материаллаг бус соёл С. Нийтийн соёл
 D. А ба С зөв E. Эдгээрээс өөр
50. Зарим оронд сайн гэж үнэлэгддэг зүйл яагаад зарим оронд эсрэгээр үнэлэгдэж болдог вэ? (2 оноо)
 А. Хэлний ялгаа В. Газар зүйн байрлалын ялгаа
 С. Хүн амын тоо, нягтшилийн ялгаа D. Боловсролын тогтолцооны ялгаа
 E. Уламжлал, зан заншлын ялгаа
51. Төрийн соёлын бодлого гэж юуг хэлэх вэ? (2 оноо)
 А. Үндэсний соёл, түүх дурсгалыг хамгаалах төрийн бодлого
 В. Үндэсний соёл болон түүний бүтээгчдэд хамаарах төрийн бодлого
 С. Нийтийн урлаг, уран сайхныг хөгжүүлэх төрийн бодлого
 D. Үндэсний бичиг үсгийг дэлгэрүүлэн хөгжүүлэх төрийн бодлого
 E. Үндэсний чанартай юм бүгдийг дээдлэх, дэлгэрүүлэх бодлого
52. Их зохиолч Д. Нацагдорж монгол дээлний дотор зангиа зүүдэг байжээ. Энэ бол соёлын ... илрэл юм. (2 оноо)
 А. Соёлын нэвчих В. Соёлын олон талт байдлын
 С. Соёлын универсаль шинжийн D. Бүгд зөв
 E. Бүгд буруу
53. Соёлын хэлбэрүүдийг онцлогтой нь зөв харгалзуулна уу. (4 оноо)
 1. Элитийн соёл А. Бүх насныхан, бүх давхаргад хүртээмжтэй
 2. Ардын соёл В. Энэ соёлын хэрэглэгчид нь нийгмийн өндөр боловсролтой хэсэг

3. Нийтийн соёл
4. Дагуул соёл
A. 1B2D3A4C
D. 1C2D3B4A
- C. Нийгмийн бүлгүүд өөрийн үнэлэмж, зан байдлын дүрмүүд, соёлыг бүтээдэг
D. Энэ соёлыг ардын билиг авъяастнууд бүтээдэг
B. 1D2C3A4B
C. 1C2A3D4B
E. 1D2B3A4C
54. “Өөрийн толгой дээрх эврийг харахгүй, бусдын толгой дээрх өвсийг харах”. Энэ нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
A. Хэм хэмжээ
D. Шүүмжлэл
B. Итгэл үнэмшил
E. Ёс суртахуун
C. Атаархал
55. Орчин үеийн олон улсын харилцааны системийг ямар гэрээтэй холбож тайлбарладаг вэ? (2 оноо)
A. Женевийн конвенц–1949 он
C. Нью Йоркийн конвенц–1979 он
E. Парисын конвенц–1993 он
B. Вестфалийн гэрээ (зарчим)–1648 он
D. Венийн конвенц–1969 он
56. Шинжлэх ухаан, боловсрол, техникийн 2салбар дахь харилцааг олон улсын харилцааны аль хэлбэрт хамааруулдаг вэ? (2 оноо)
A. Олон улсын улс төрийн харилцаа
C. Олон улсын соёлын харилцаа
E. Эдгээрээс өөр
B. Олон улсын эдийн засгийн харилцаа
D. Бүгдэд нь
57. Өөрийн хүчийг нэмэгдүүлж, эсрэг эвсэлтэй тэмцэлдэж, устгах, гишүүдийг нь өөртөө татах, гишүүнээ бусдад алдахгүй байхыг зорилго болгодог систем аль нь вэ? (2 оноо)
A. Хоёр туйлт
D. Гурван туйлт
B. Олон туйлт
E. Өмнөд, умард туйлт
C. Нэг туйлт

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Дараах өгөгдлийг зөв харгалзуул. (5 оноо)
A. Эрх мэдэл нь тавьсан зорилгын хэрэгжилт, зорилгодоо хүрэх чадвар юм
B. Эрх мэдэл нь үйл байдлын хэв маяг. Энэ хэв маягт зарим нь тушааж, зарим захирагддаг
C. Хүнд угаас эрх мэдэл рүү тэмүүлдэг чанар оршдог. Иймд эрх мэдэл бол баялаг, нэр хүнд, эрх чөлөө зэргийг олж авч улмаар амьдралаа сайжруулах арга хэрэгсэл юм
D. Эрх мэдэл нь системийн нийтлэг зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн системийн өөрийнх чадвар юм
E. Хүн хүнээ эзэмдэх гэсэн сэтгэцийн хүсэл хандлага
- 2.2. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)
A. Харьцангуй, хурдтай, мөн чанараараа өөрчлөгдөж байгаа чанарын өөрчлөлт
B. Материаллаг болон оюун санааны объектуудын эргэлт буцалтгүй нэг зүгт чиглэсэн өөрчлөлт
C. Нийгмийн тогтолцоо, нийтлэг байгууллагууд нэг нөхцөл байдлаас нөгөөд шилжиж буй шилжилт
D. Түүхэн үйл явцын бүхлийн нэг хэсэг, сансар огторгуйн, төгсгөлгүй, олон янз, идэвхтэй хувьслын нэг тал
E. Объектуудын байнгын, удаан, нэг хэвийн, тооны талын өөрчлөлт
- 2.3. Зөв харгалзааг тогтооно уу. (4 оноо)
A. Үнэлгээний ядуурал
B. Харьцангуй ядуурал
C. Хэрэгцээний ядуурал
D. Хүнс тэжээлийн зардлын
E. Туйлын ядуурал
1. Г. Лассуэл
2. Т. Парсонс
3. Б. Рассел
4. З.Фрейд
5. Бихеворист
1. Нийгмийн өөрчлөлт
2. Нийгмийн хөгжил
3. Хувьслын үйл явц
4. Хувьсгалт үйл явц
5. Нийгмийн хувьсгал
1. Амьжиргааны доод түвшингээс доогуур амьдарч буй
2. Ядуучууд бусдаас хэрхэн доогуур амьдарч буйг илтгэх бөгөөд байр сууц, хөрөнгө мөнгө, боловсрол, эрүүл мэнд гэх мэтийн зүйлээр хангагдаж чадахгүй байгаа
3. Гэр бүлийн хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүнийн илчлэг чанараар тодорхойлогдох
4. Амьжиргааны доод түвшингийн 40 хувьд хүрэхгүй байгаа ядуурал
5. Дэлхийн банкнаас тогтоосон ядуурлын дээд шугамд хүрэхгүй байгаа

ХУВИЛБАР D

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

- Нийлмэл нийгмийн шинжид үл хамаарах зүйлийг олно уу ? (1 оноо)
 А. Төр В. Шинжлэх ухаан С. Эрх зүй
 D. Нийгмийн давхраажил E. Нийгмийн тэгш байдал
- Нийгмийг тодорхойлох синергетик хандлага аль нь вэ? (1 оноо)
 А. Нийгэм дэх үзэгдэл, үйл явц аяндаа өөрөө цэгцрэн хөгждөг
 B. Нийгэм бол үндсэн болон дэд тогтолцооноос бүрддэг
 C. Нийгэм бол нийгмийн институт буюу байгууллагуудын хүрэн дэх амьдралын хэрэгцээг үйл ажиллагаагаар хэрэгжүүлж буй хүмүүсийн цогц юм
 D. Нийгэм нь хувь хүмүүс, тэдгээрийн хоорондын харилцааны цогц мөн
 E. Нийгэм бол тодорхой хил хязгаар бүхий нутагт хамтран аж төрж буй хүмүүсийн нэгдэл юм
- Хүн төрөлхтний түүх, нийгмийн амьдралыг соёл гэдэгт хамааруулан энэ соёл иргэншил нь бие биеэсээ хамааралгүйгээр орчил байдлаар хөгжинө гэсэн нь аль онол сургаалд хамаарах вэ? (1 оноо)
 А. Газар зүйн үзэл В. Биологийн үзэл С. Элитийн онол
 D. Иргэншлийн онол E. Эдийн засгийн онол
- Дахин давтагдашгүй өвөрмөц шинж бүхий тодорхой хүнийг ямар ойлголтоор илэрхийлдэг вэ? (1 оноо)
 А. Хүн В. Иргэн С. Хувь хүн
 D. Төр E. Соёл
- Германы философич О.Шпенглер тухайн нэг иргэншил ямар үе шатуудыг дамждаг гэж үзсэн бэ? (1 оноо)
 А. Үүсэл- Өсөлт-Бууралт- Уналт-Бутрал В. Залуу нас-Цэцэглэлт- Уналт
 C. Эхлэл-Өрнөлт- Бутрал D. Залуу нас-Хөгжилт- Бууралт
 E. Үүсэл- Өсөлт- Уналт
- Монгол улсын Үндсэн хуулинд "...байгаль орчноо хамгаалах үүрэгтэй" гэж заасан байдаг нь Монгол улсын иргэний мөн. (1 оноо)
 А. Журамт үүрэг В. Үндсэн үүрэг С. Үндсэн эрх
 D. Иргэний эрх E. Ийм заалт байхгүй
- Төрийг эртний, дорно дахины, грек-ромын, дундад үеийн, шинэ үеийн хэмээн ангилсан нь төрийн хэв маягийн ангиллын алинд нь хамаарах вэ? (1 оноо)
 А. Эртний ангилал В. Марксист ангилал С. Иргэншлийн хандлага
 D. Түүхэн хөгжлийн ангилал E. Орчин үеийн ангилал
- Улс төрийн намыг зохион байгуулалт ба үйл ажиллагааны аргаар нь хэрхэн ангилдаг вэ? (2 оноо)
 А. Боловсон хүчний, олон түмний В. Эрх баригч, сөрөг С. Ардчилсан, төвлөрсөн
 D. Зүүний, барууны E. Консерватив, либерал
- Төрийн өмчийг ашигласны төлөө төлөх татварын төрлийг . . . гэнэ. (1 оноо)
 А. Төлбөр В. Шууд бус татвар С. Хураамж
 D. Шууд татвар E. Шимтгэл
- Инфляци өсөх хандлагатай байвал та дараахи үйлдлүүдийн алиныг хийсэн нь дээр гэж бодож байна вэ? (2 оноо)
 А. Мөнгөө банкинд хадгалуулна В. Мөнгөөрөө байр худалдан авна
 C. Байраа үнэтэй машинаар солино D. Байраа бэлэн мөнгөөр үнэ хүргэж зарна
 E. Мөнгөө хүнд зээлдүүлнэ
- Зээлийн хүүгийн үндсэн үүрэг нь: (1 оноо)
 А. Бүтээлч капиталыг хуваарилах үүрэг
 B. Мөнгөн капиталын хуваарилалтын үүрэг
 C. Мөнгөний эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах үүрэг
 D. Мөнгөн хуримтлалыг нэмэгдүүлэх үүрэг
 E. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үүрэг
- Сайхан хүн хэмээх ойлголтын үндсэн агуулгад үл хамаарах зүйл аль нь вэ? (1 оноо)
 А. Зөв сэтгэлтэй хүн C. Хариуцлагатай хүн
 D. Шударга хүн E. Бүгд хамаарна
- Соёлын түгээмлүүдэд аль нь үл хамаарах вэ? (1 оноо)
 А. Биеийн чимэглэл В. Зочлох ёс С. Тоглоом
 D. Баяр ёслол E. Хөөмий

14. Дараах байгууллагуудын аль нь НҮБ-ын төрөлжсөн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байдаг вэ? (1 оноо)
 А. Хүний эрхийн дээд комиссарын газар
 В. Ерөнхий ассамблей
 С. Эдийн засаг, нийгмийн зөвлөл
 D. Аюулгүйн зөвлөл
 E. Нарийн бичгийн дарга нарын газар
15. Дараах бодомжуудын аль нь зөв бэ? (1 оноо)
 А. Хүн бүхэн бие хүн мөн
 В. Зарим хүн бие хүн мөн
 С. Хүүхэд эхээс төрөхдөө бие хүн байдаг
 D. Дээрх хариулт бүгд худлаа
 E. Дээрх хариулт бүгд үнэн
16. Оюун санааны харилцаанд аль нь хамаарах вэ? (1 оноо)
 А. Гэр бүлийн харилцаа.
 В. Удирдах, удирдуулах харилцаа
 С. Ёс суртахууны харилцаа
 D. Зах зээлийн харилцаа
 E. Соёлын харилцаа
17. Боловсролын институтын үндсэн үйл ажиллагаанд аль нь хамаарах вэ? (1 оноо)
 А. Хүн бүрт шинжлэх ухааны мэдлэгийг зохих түвшинд эзэмшүүлэх
 В. Шударга ёс, хуулийг дээдлэн сахидаг иргэнийг төлөвшүүлэх
 С. Байгаль орчноо хайрлан хамгаалдаг иргэнийг төлөвшүүлэх
 D. Бие даан суралцах, ажиллаж амьдрах чадвартай иргэнийг төлөвшүүлэх
 E. Дээрхи бүгд хамаарна
18. Нийгмийг амьтны физиологийн бүтэцтэй адилтган интеграци, дифференцийн зарчмаар тайлбарласан сэтгэгчийг нэрлэнэ үү. (1 оноо)
 А. Л.И.Мечников
 В. Л.Н.Гумилев
 С. Г.Спенсер
 D. К.Маркс
 E. Мальтус
19. Аль нь нийгэмшлийн хүчин зүйлүүдэд шууд хамаарагдахгүй вэ? (1 оноо)
 А. Боловсролын түвшин
 В. Хэлний мэдлэг
 С. Гэр бүлийн орчин
 D. Хамт олны хүрээлэл
 E. Нутаг дэвсгэрийн хэмжээ
20. “Ургийн бичиг” хөтлөхийн гол ач холбогдол нь: (1 оноо)
 А. Хүн өөрийн овог удмаа мэддэг болох
 В. Бичиг баримт хөтөлж сурах
 С. Нэр хүндээ дээшлүүлэх
 D. Эд баялаг, өмч хөрөнгөтэй болох
 E. Иргэний үнэмлэх авах
21. Судлаач Дойч нийгмийн шинжлэх ухаан түүний дотор улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжлийн үе шатыг тодорхойлсон байдаг. Энэхүү үе шатыг дурьдахдаа буруу зүйл бичсэн байвал тэмдэглэнэ үү? (1 оноо)
 А. Эмпирик үе
 В. Рефлексийн үе
 С. Шашны үе
 D. Философийн үе
 E. Бүгд зөв
22. Аль нь либерализмын сургаалд тохирох вэ? (1 оноо)
 А. Үндэсний үзлийг дээдэлсэн сургаал мөн
 В. Либерализм бол тэгш эрхийг дээдэлдэг сургаал мөн
 С. Эдийн засгийн зохицуулалтыг төр хийх ёстой гэж үздэг
 D. Хүний сайн сайханд итгэдэг, хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг
 E. Нийгэмд өвлөгдөж ирсэн үнэт зүйлсийг дээдэлдэг
23. Demos, Kratos гэсэн үг тус бүрдээ ямар утга, гарлыг илэрхийлдэгийг доорх өгөгдлөөс олно уу. (2 оноо)
 А. “улс”, “төр”, латин үг
 В. “улс”, “иргэн”, грек үг
 С. “ард түмэн”, “засаг”, грек үг
 D. “төр”, “нийгэм”, латин үг
 E. эдгээрээс өөр
24. Барааны хомсдол гэж юу вэ? (2 оноо)
 А. Үйлдвэрлэлийн хэмжээ буурах
 В. Нийлүүлэлтийн хэмжээ багасах
 С. Хүмүүсийн хэрэгцээт бараа дутагдалтай болох
 D. Эрэлтийн хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс их байх
 E. Нийлүүлэлтийн хэмжээ эрэлтийн хэмжээнээс их байх
25. Зөв холбоно уу. (3 оноо)
 1. Борлуулагч
 а. Зар сурталчилгааны менежер
 2. Хэрэглэгч
 б. Савлагч
 3. Үйлдвэрлэгч
 в. Өрх гэр
 А. 1б, 2в, 3а
 В. 1а, 2б, 3в
 С. 1б, 2а, 3в
 D. 1а, 2в, 3б
 E. 1в, 2а, 3б

26. “. . . бол нийгэмшилтийн явцад хүний эзэмшдэг зүйл. (1 оноо)
 . . . бол хүнийг хүн болгодог зүйлийн нэр
 . . . бол бэлэн үлгэр, загварын асар баян сан
 . . . бол хүний сурдаг бүх зүйл
 . . . бол хүний амьдралыг зохион байгуулдаг.” гэсэн бодомжууд нь аль өгөгдлийг илэрхийлж байна вэ?
 А. Нийгэмшилт В. Соёл С. Мэдлэг
 D. Утгын ертөнц E. Удамшил
27. Монгол улсын үндсэн хуулиар тунхагласан иргэний үндсэн эрхүүдийг тоочихдоо үл хамаарах зүйл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
 А. Амьд явах В. Эрүүл аюулгүй орчинд амьдрах
 С. Албан татвар төлөх D. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох
 E. Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох
28. Баяр, Саран хоёр гэрлэснийхээ дараа захиалсан орон сууц нь ашиглалтад орохыг хүлээж Сарангийн аавын нэг өрөөнд 1 жил амьдрал. Энэ байдал гэр бүлийн талаарх өгөгдлүүдийн алинд хамаарах вэ? (1 оноо)
 А. Полигени В. Матриархаль С. Матрилокаль
 D. Эндогами E. Патрилокаль
29. Аливаа хүн өөртэйгөө, бусад хүмүүстэй, байгальтай, нийгэмтэй, эд юмстай харилцах харилцааг журамлаж, зөв сайн амьдрах арга ухаанд суралцаж, хүн шиг хүн болж төлөвшихөд анхдагч нөлөө бүхий зүйл аль нь вэ? (1 оноо)
 А. Эрх зүйн хэм хэмжээ В. Эрх зүйн ухамсар С. Эрх зүй
 D. Ёс суртахууны хэм хэмжээ E. Ёс суртахууны ухамсар
30. “Чи миний төлөө юм хийнэ, яагаад гэвэл чи намайг хүндэлдэг” гэж хэлэх нь эрх мэдлийн ямар хэлбэр вэ? (2 оноо)
 А. Хүч хэрэглэх эрх мэдэл В. Үүрэг үүсгэх эрх мэдэл
 С. Наймаалцах эрх мэдэл D. Хүндлүүлэх эрх мэдэл
 E. Итгүүлэх эрх мэдэл
31. Үндсэн хуульд зааснаар Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, ургамал, амьтан болон байгалийн бусад баялаг . . . байна. (1 оноо)
 А. Ард түмний мэдэл, төрийн хамгаалалтанд
 В. Төрийн мэдэл, ард түмний хамгаалалтанд
 С. Ард түмний мэдэл, бүх нийтийн хамгаалалтанд
 D. Төрийн мэдэл, төрийн хамгаалалтанд
 E. Төрийн мэдэл, олон улсын хамгаалалтанд
32. Аль нь засаглалын легитим шинж вэ? (1 оноо)
 А. Засаг нь хууль ёсны байна, төрийн үйл ажиллагаа нь олон түмний дэмжлэгийг хүлээх ёстой
 В. Засаг нь хууль ёсны байна, төрийн үйл ажиллагаанд олон түмний оролцоог хүлээн зөвшөөрдөггүй
 С. Өрсөлдөөний бус засагтай, төрийн үйл ажиллагаанд олон түмний дэмжлэгийг авах ёстой
 D. Засаг нь хууль ёсны байна, төрийн үйл ажиллагаа нь олон түмний дэмжлэгийг хүлээгээгүй
 E. Засаг нь хууль ёсны бус, төрийн үйл ажиллагаанд олон түмэн оролцохыг ихэд хүсдэг
33. Сонирхлын бүлгүүд улс төрийн үйл ажиллагааны дараахи төрлүүдийн алиныг нь голлон хэрэгжүүлдэг вэ? (1 оноо)
 А. Сонирхлыг бодлого болгон боловсруулах В. Сонирхол илэрхийлэх
 С. Сонирхлыг дамжуулах D. Сонирхлыг замхруулах
 E. Сонирхлыг хэрэгжүүлэх
34. Улс төрийн үйл явцыг улс төрийн субъектуудын үйл байдлаар дамжуулан судалдаг арга бол: (2 оноо)
 А. Шийдвэрийн арга В. Бихевиорист арга
 С. Системийн арга D. Психологийн арга
 E. Харьцуулах арга
35. Бэлэн мөнгөний давуу тал юу вэ? (2 оноо)
 А. Хадгалахад хялбар байдаг В. Хүн бүрийн хэрэгцээнг тохирдог
 С. Тооцоо хийхэд хялбар байдаг D. Түргэн эргэлттэй байдаг
 E. Худалдаа хийхэд хялбар байдаг
36. Бага зардлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнийгээ хурдан хугацаанд борлуулж чадсан нь ашиг олж, цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой болно. Ингэж чадаагүй нь дампуурч зах зээлээс гарах хууль үйлчилнэ. Үүнийг шалгарлын хууль гэх ба эдийн засгийн ямар ойлголтоор дамжин хэрэгжих вэ? (2 оноо)

- А. Эрэлт, нийлүүлэлт
D. Өрсөлдөөн
- В. Ажилгүйдэл
E. Инфляци
- С. Үл үзэгдэгч гар
37. Тогтмол зардлыг тодорхойлно уу? (1 оноо)
А. Түүхий эдийн зардал
D. Тээврийн үйлчилгээний хөлс
В. Эрчим хүчний зардал
E. Хөдөлмөрийн нөөцийн зардал.
С. Рентийн төлбөр
38. Хоол хүнс, хувцас, орон байр, оюун санаа, соёлын үнэт зүйлс, боловсрол, эрүүл мэнд, хүний эрх гэх мэт хүн бүрт шаардагдах бүх зүйлийг ... гэнэ. (1 оноо)
А. Материаллаг хэрэгцээ
D. Нийгмийн хэрэгцээ
В. Хэрэгцээ
E. Анхдагч хэрэгцээ
С. Хувийн хэрэгцээ
39. Монголын ерөнхий боловсрол 2008-2009 оны хичээлийн жилд 12 жилийн тогтолцоонд шилжинэ. Энэ нь аль өгөгдөлд хамаарах вэ? (2 оноо)
А. Нийгмийн шинэтгэл (реформ)
C. Нийгмийн дэвшил
E. Эдгээрээс өөр
В. Нийгмийн шинэчлэл (модернизация)
D. Нийгмийн хувьсгал
40. Эртний Грекийн философич Аристотель өөрийн амьдарч байсан нийгмийнхээ давхрааны хамгийн доод хэсгийнхнийг “ярьдаг зэвсэг” гэж нэрлэж байжээ. Тэгвэл Аристотелийн “ярьдаг зэвсэг” гэж нэрлэсэн нийгмийн тэр хэсэг нийгмийн давхраажилтын аль хэв маягийг илэрхийлж байна вэ? (1 оноо)
А. Анги
D. Боолчлол
В. Каст
E. Аль нь ч биш
С. Язгуур
41. Үндсэн хуульд зааснаар аль нь Монгол улсын нийслэл вэ? (2 оноо)
А. Монгол улсын шинжлэх ухаан, боловсрол, соёлын байгууллагууд төвлөрсөн хот
В. Монгол улсын эдийн засгийн гол үндэс болсон аж үйлдвэр төвлөрсөн хот
C. Монгол улсын иргэд хамгийн олноороо оршин суудаг
D. Монгол улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хот
E. Монгол улсын эдийн засгийн нээлттэй хамгийн их хүн ам оршин суудаг хот
42. Хүн амыг бүхэлд нь юм уу эсвэл нийгмийн нэг тодорхой хэсгийг төлөөлсөн бүлэг хүмүүс ба байгууллагын төрийн засаглалд нөлөөлөх, оролцох идэвхтэй үйлдлийг улс төрийн шинжлэх ухаанд юу гэх вэ? (2 оноо)
А. Улс төрийн шийдвэр
C. Улс төрийн соёл
E. Улс төрийн бодлого
В. Улс төрийн дэглэм
D. Улс төрийн үйл ажиллагаа
43. Ямар системийг чөлөөт үнийн систем гэдэг вэ? (2 оноо)
А. Хэрэглэгчид өөрийн худалдан авах чадварын түвшингээр зах зээлийн үнийг тогтоох
В. Үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ үнийг чөлөөтэй сонгох
C. Мөнгөөр баталгаажсан хэрэглээнээс хамаарч бүтээгдэхүүний үнэ бүрдэх систем
D. Бүтээгдэхүүний үйлчилгээнээс хамаарч үнэ бүрдэх систем
E. Бүгд зөв
44. Зөв холбоно уу? (3 оноо)
1. Мөнгөний бодлого
2. Төв банк
3. Банк
4. Зээлийн хүү.
5. Мөнгө
а. Зээлдүүлсний төлөө өгч байгаа нэмэлт төлбөр
б. Бараа таваар, эд баялагийн оронд төлбөр болгож авахыг бүх нийтээр зөвшөөрч байгаа солилцооны хэрэгсэл
в. Мөнгөн хөрөнгийг хуримтлуулах, зээлдүүлэх, мөнгөн тооцоо хийх, гүйлгээнд зээлийн хөрөнгө оруулах, үнэт цаас гаргах зэрэг үүрэг гүйцэтгэгч онцгой байгууллага
г. Эдийн засаг дахь мөнгөний нийт тоонд болон тэдгээрийг тавьж олгох өртөг буюу хүүгийн хэмжээнд нөлөөлөх
д. Төрийн мөнгөний бодлогыг зохицуулж, улсын эдийн засгийг мөнгөний бодлогоор дамжуулан удирдаж байдаг санхүү эдийн засгийн төв, төрийн байгууллага
А. 1а, 2д, 3в, 4г, 5б
D. 1д, 2а, 3в, 4г, 5б
В. 1г, 2д, 3в, 4а, 5б
E. 1г, 2а, 3в, 4в, 5д
С. 1в, 2д, 3а, 4г, 5б
45. “Эрдэм их болог, ойлгоц сайн болог” гэж монголчууд үздэг. Энэ нь алинд нь хамаарах вэ? (1 оноо)
А. Монголын бэлгэдэл
D. Монгол ёс зүй
В. Монголчуудын шүтлэг
E. Монголчуудын урлаг
С. Монголын гүн ухаан
46. Манай ард түмэн байгалийг хайрлан хамгаалах талаар баялаг уламжлалтай. Байгаль орчноо хамгаалах хорио цээрлэлийн уламжлалд үл хамаарах зүйл аль нь вэ? (1 оноо)
А. Хавар өвс ногоо ургах вед газар шороогоо ухаж сэндийчихгүй байх
В. Нойтон мод, бут сөөг, гол горхи, булаг шандын эхний модыг огтлохгүй байх
С. Шувууг тэнгэрийн амьтан хэмээн хүндэтгэж алж устгадахгүй байх

- D. Гол мөрний усанд бохир зүйл хийхгүй байх
E. Бүгд хамаарна
47. НҮБ-ын гол байгууллагын нэг Эдийн засаг ба нийгмийн зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдолгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
A. Гурван жилийн хугацаатай сонгогддог
B. 54 гишүүн оронтой
C. Жилд 18 улсыг сольдог
D. Төрөлжсөн байгууллагын нэг
E. ЮНЕСКО түүний эгнээнд нь багтдаг
48. Улс төрийн элит гэж хэнийг хэлэх вэ? (1 оноо)
A. Мэргэжлийн улс төрч хэн боловч элит мөн
B. Нийгмийн өндөр эрх мэдэлтнүүдийг элит гэнэ
C. Эрх мэдэл, оюуны ба ёс суртахууны эрхэм чанар, зохион байгуулах авъяас, төр ба мэдээллийн засаглалд үлэмж жинтэй, том биш бие даасан социаль бүлгийн гишүүнийг элит гэнэ
D. Олон нийтэд танил болсон улс төрчдийг элит гэнэ
E. Мэргэжлийн улс төр судлаачид бол улс төрийн элитүүд мөн
49. Аль нь төрийн мөн чанар, гарал үүслийн тухай шашны онолын үзэл баримтлал вэ? (2 оноо)
A. Төр бол дарлагч ангийн ноёрхлын зэвсэг мөн
B. Төр бол нийгмийн тодорхой бүлгийн эрх ашгийг хамгаалах байгууллага мөн
C. Төр бол ард түмэн, засаглалын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр бий болсон байгууллага мөн
D. Төр бол нийгмийн сайн сайхны төлөө байгууллага мөн
E. Аль нь ч биш
50. Аль нь дээдийн дээд давхрааг тодорхойлох вэ? (2 оноо)
A. Хөх захтан
B. Шинэхэн баян
C. Үе залгамжилсан сурвалжтан
D. Өндөр нэр хүндтэй эмч
E. Мянгат малчин
51. Нийгэм дэх шилжих хөдөлгөөний хэлбэрүүдийн дараах жишээнүүдээс үл хамаарахыг ол. (2 оноо)
A. Жүжигчин А. Шварцнеггер Калифорни мужийн амбан захирагч болжээ
B. Мянгат малчин Болд зуднаар бүх малаа алдаж хоосорч ядуурчээ
C. Багш Дорж Улаанбаатар хотоос Булган аймаг руу шилжин суурьшсан
D. Иргэн Дулам бизнес хийхээр Бээжин хот руу явсан
E. Үл хамаарах жишээ байхгүй
52. Нийлүүлэлт багасвал (2 оноо)
A. Үнэ өснө, тоо хэмжээ өснө
B. Үнэ буурна, тоо хэмжээ буурна
C. Үнэ буурна, тоо хэмжээ өснө
D. Үнэ өснө, тоо хэмжээ буурна
E. Тэнцвэрт үнэ тогтоно
53. Зөв холбоно уу. (3 оноо)
1. Бүрэн ажил эрхлэлт а. Тодорхой нэг салбар, мэргэжлийн цар хүрээ хумигдан, шинэ салбар, мэргэжлийн шаардлага өссөнтэй холбоотой ажилгүйдэл
2. Ажилгүйдэл б. Эдийн засгийн бууралтын үед бий болдог ажилгүйдэл
3. Зөрөөний буюу завсрын ажилгүйдэл в. Ажилгүйдэл ердийн төвшинд байх үзэгдэл
4. Бүтцийн ажилгүйдэл г. Хүмүүс нэг ажлаас нөгөө ажилд шилжих хооронд үүсдэг ажилгүйдэл
5. Мөчлөгийн ажилгүйдэл д. Хөдөлмөрийн зах зээл дээрх мөчлөгт үзэгдэл бөгөөд ажиллах хүчний эрэлтээс нийлүүлэлт давснаар илэрнэ
A. 1а 2д 3г 4в 5б B. 1б 2д 3г 4в 5а C. 1г 2а 3в 4д 5б
D. 1д 2г 3в 4а 5б E. 1в 2д 3г 4а 5б
54. Засгийн газраас махны үнийг зах зээлийн тэнцвэрт үнийн түвшингөөс доогуур байлгаж байна гэж үзье. Энэ нь зах зээлийн эдийн засгийн хувьд ямар үр дүнд хүргэх вэ? (2 оноо)
A. Мах үйлдвэрлэгчдийн мах үйлдвэрлэх сонирхол буурч зах, зээлд хомсдол бий болно
B. Одоо байгаа махыг хуваарилахад үнэ маш бага нөлөөтэй болно
C. Хэрэглэгчид махны хязгаарлагдмал байдлын талаар буруу мэдээлэлтэй болно
D. Дээрх бүгд зөв
E. Дээрх бүгд буруу
55. Төв Азийн бүс нутаг дахь олон улсын терроризм, шашны экстремизм, үндэсний салан тусгаарлах үзлийн эсрэг эдгээр орнуудын хүчийг нэгтгэх, мөн харилцан итгэлцэл, найрсаг харилцааг бэхжүүлэх, улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техник, технологи, экологийн болон бусад салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх, энэ бүс нутагт аюулгүй тогтвортой байдлыг хангах зорилготой олон улсын байгууллагыг нэрлэнэ үү. (2 оноо)
A. НҮБ
B. Дэлхийн банк
C. НАТО
D. АПЕК
E. ШХАБ

56. Доорх өгөгдлүүдийн зөв харгалзааг сэргээнэ үү. (3 оноо)
- | | | |
|-------------------------|--|----------------|
| 1. Ерөнхий Ассамблей | A. НҮБ-ын бичиг хэргийг хариуцдаг | |
| 2. Аюулгүйн зөвлөл | B. НҮБ-ын энхийг сахиулах үүрэгтэй гол байгууллага | |
| 3. Олон улсын шүүх | C. Дэлхийн энх тайванд холбогдолтой бүхий л асуудлаар хуралддаг | |
| 4. Нарийн бичгийн дарга | D. Янз бүрийн улс хооронд дахь маргаантай нарын газар асуудлыг шийдвэрлэнэ | |
| A. 1B 2C 3A 4D | B. 1D 2C 3A 4B | C. 1C 2D 3A 4B |
| D. 1B 2D 2A 4C | E. 1C 2B 3D 4A | |
57. Монголчуудын гадаад харилцааг хэдий үеэс эхэлсэн гэж үздэг вэ? (2 оноо)
- | | | |
|-----------------------|---|----------------|
| A. МЭӨ III зууны үеэс | B. Монгол нутаг дахь эртний улсууд оршин тогтнох үеэс | |
| C. XIII зуунаас | D. XVII зуунаас | E. XIX зуунаас |

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Дараах өгөгдлийг зөв харгалзуулаарай. (5 оноо)
- | | |
|--|---------------------------|
| A. Бусад оронтой хийх олон улсын тооцоонд ашиглаж буй тухайн орны мөнгөний нэгж | 1. Чөлөөтэй хөврөх валют |
| B. Нэг л орны дотор үйлчилж, бусад улсын валютаар арилжигдахгүй үндэсний валют | 2. Валютын арилжааны ханш |
| C. Гадаадын аль ч валютаар чөлөөтэй хязгаарлалгүй арилжигдах | 3. Хязгаартай валют |
| D. Өөр улсын мөнгөний нэгжээр илэрхийлсэн аль нэг улсын мөнгөний валют нэгжийн үнэ | 4. Үндэсний валют |
| E. Гадаад худалдааны үйл ажиллагаа явуулах, гадаадын хөрөнгө оруулалтын тооцоонд үнэ тодорхойлоход ашиглаж буй тэргүүлэх орнуудын үндэсний мөнгө-зээллэгийн хэрэгсэл | 5. Нөөц валют |
- 2.2. Зөвийг харгалзуулна уу. (5 оноо)

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр	A. Бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настанд сувилахуйн үйлчилгээ үзүүлэх,
2. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж	B. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр
3. Нийгмийн халамжийн үйлчилгээ	C. Төрийн байгууллагын оролцоотойгоор нийгмийн эмзэг бүлгийн нэн тэргүүний хэрэгцээг тодорхойлох, амьжиргааг дээшлүүлэх, дэмжин туслах үйлчилгээ
4. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	D. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж

- 2.3. Өгөгдлийг зөв тохируулна уу. (5 оноо)
- | | |
|--|------------------------|
| A. Хүний эрх чөлөөний асуудлыг гол болгож, хөгжил дэвшилд уламжлалыг эрхэм болгодог | 1. Барууны нам |
| B. Нийгмийн чиг баримжааг гол болгож, хөгжил дэвшилд шинэчлэл хийхийг эрхэм болгодог | 2. Зүүний нам |
| C. Нийгмийн баазын хувьд өргөн биш, гол төлөв мэргэжлийн улс төрчид, улс төрийн зүтгэлтэн, улс төр, санхүүгийн элитэд тулгуурласан нам | 3. Боловсон хүчний нам |
| D. Өөрийн намын мөрийн хөтөлбөрөөс гажихгүй боловч түүнийг амьдралд хэрэгжүүлэх талаар өөр байр суурь, үзэл бодолтой, зохион байгуулалтын бүтэцтэй, намын доторх онцгой бүлэглэл | 4. Фракц |
| E. Нийгмийн өргөн баазад суурилдаг, дүрмээр нэгдсэн, хатуу гишүүнчлэлтэй, зохион байгуулалт, сахилга батын хувьд нарийн чанд намууд | 5. Олон түмний нам |

2011 оны Нийгмийн тухай мэдлэг хичээлийн даалгаврын түлхүүр

№	Хувилбар							
	A	Оноо	B	Оноо	C	Оноо	D	Оноо
1	B	1	B	1	E	1	E	1
2	E	1	D	2	B	2	A	1
3	A	1	A	1	E	2	D	1
4	A	1	A	1	D	1	C	1
5	C	1	A	1	B	1	B	1
6	E	1	C	2	C	2	A	1
7	C	1	A	1	A	1	D	1
8	A	3	C	1	D	1	C	2
9	B	1	C	2	C	1	A	1
10	D	1	A	2	A	2	B	2
11	D	1	D	2	D	1	B	1
12	B	1	E	1	D	1	E	1
13	B	1	D	1	E	1	A	1
14	B	1	B	1	D	1	C	1
15	E	1	E	1	B	1	B	1
16	C	2	E	1	D	1	C	1
17	B	1	C	1	B	1	E	1
18	B	1	A	1	D	1	C	1
19	D	1	E	1	C	1	E	1
20	B	4	E	1	B	1	A	1
21	C	1	A	3	E	1	C	1
22	B	2	B	1	B	1	D	1
23	D	1	A	2	B	1	C	2
24	D	3	E	1	B	1	D	2
25	A	4	E	2	C	3	D	3
26	B	4	B	2	B	2	B	1
27	B	1	B	1	A	1	C	1
28	E	1	D	2	C	1	C	1
29	A	1	C	2	A	1	D	1
30	D	2	C	2	D	1	B	2
31	C	2	A	1	B	1	A	1
32	B	2	D	1	E	1	A	1
33	A	1	C	2	E	1	B	1
34	D	1	A	2	A	1	B	2
35	A	2	A	2	D	1	D	2
36	D	1	D	2	D	1	D	2
37	A	2	B	2	C	1	C	1
38	A	1	D	1	B	1	B	1
39	A	2	B	2	C	1	A	2
40	B	1	B	1	D	1	D	1

№	Хувилбар							
	A	Оноо	B	Оноо	C	Оноо	D	Оноо
41	B	2	C	1	B	3	D	2
42	C	2	E	1	B	2	D	2
43	C	1	B	2	C	2	C	2
44	B	3	C	1	B	2	B	3
45	E	2	C	1	D	2	A	1
46	E	1	C	1	C	3	A	1
47	D	1	B	1	B	2	D	2
48	C	1	C	1	A	3	C	1
49	A	3	C	1	B	2	E	2
50	C	1	A	1	E	2	C	2
51	A	1	C	2	B	2	D	2
52	C	1	A	2	A	2	D	2
53	C	1	D	2	A	4	E	3
54	E	2	E	2	E	2	A	2
55	B	1	B	1	B	2	E	2
56	C	1	B	3	C	2	E	3
57	C	1	A	4	A	2	A	2
2.1	1c2a3e4b5d	5	1d2c3a4b5e	5	a3b5c1d2e4	5	a4b3c1d2e5	5
2.2	1b2c3e4d5a	5	1c2a3e4b5d	4	a4b2c1d5e3	5	1b2d3c4a	5
2.3	1c2a3d4b	4	1e2a3d4c5b	5	a1b5c2d3e4	4	a1b2c3d4e5	5
Нийт		100		100		100		100

